

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Д.Хайвжунай	Дугаар	L251
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Сэврэй сум
Төрсөн газар	Сэврэй сум	Төрсөн он	1919
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цагаан суварганы хурал	Сүм хийдийн дугаар	ӨГСВ 006
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 1	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Өмнөговь аймгийн Сэврэй сумын Цагаан суварганы хурал

Хайвжунай : За даа би чинь тэгээд эндээ багадаа эндээ байж л байсан.Би бол нэг дөрвөн настай л ахыгаа дагаж ирээд л ...Тэгэхэд манай ах Ням гэдэг хүн, эндхээр Найдан гэж л бас нэг алба байж л дээ.

Гантулга: Найдан лам?

Хайвжунай: Тийм.Тэгээд сүүлд нь ловон болоод л тэгж байж байгаад тэгээд л баригдаад тэгээд хороогдсон доо.

Гантулга: Найдан гэдэг чинь ямар алба байсан бэ?

Хайвжунай: Ухаандаа ловонгийн орлогч л юм уу даа/инээв/

Гантулга: Аан за за , энэ Цагаан суварганы хийд гээд байна ш дээ?

Хайвжунай :Аан.

Гантулга: Энийг чинь одоо Цагаан суварганы хурал ч гэж нэрлэж байна, өөр юу гэж нэрлэж байсан бэ?

Хайвжунай:Үгүй ээ энэнээс өмнө бол Маанийн хурал гэж байсан юм гэсэн.Тэгээд сүүлд нь энэ Цагаан суварганы хурал гэдэг л болсноос биш.Дээрээс өгсөн тэр нэрийг нь би мэдэхгүй юм, байгаагүй байх аа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Бас нэг Шандын хурал гээд, Сайншанд?

Хайвжунай: Аа тэр ч яахав газрын нэр л дээ, Сайншанд гэж. Сайншандын хурал л гэдэг байсан юм. Тэр чинь энэ Сайншанд гэдэг газрын нэр юм.

Гантулга: Одоо энэ сэргээчихээд байгаа цагаан суварга чинь хуучин байсан суварганы ор уу?

Хайвжунай: Яг тийм, энд байсан хоёр суварга байсан юм. Тэгээд тэр нэг нь тэр өвөр дор нь байсан юм. Аа тэр хойд орой дээр нь байгаа тэрэн дээр нь ахиж байгуулаад байгаа юм.

Гантулга: Харин тийм байна. Тэгээд тэр Цагаан суварга байсан болоод Цагаан суварга байсан юм болов уу даа, нэр нь?

Хайвжунай: Тэгсэн байх.

Гантулга: Магадгүй тийм ээ?

Хайвжунай: Тэгсэн байх.

Гантулга: Та энэ Цагаан суварганы хурлаас өөр хуралд явж очиж шавилан сууж байсан уу?

Хайвжунай: Үгүй.

Гантулга: Энэ ойр хавийн хурлууд дээрээ очиж байгаагүй юу?

Хайвжунай: Үгүй ээ үгүй. Очиж байгаагүй.

Гантулга: Та хэдэн он хүртэл энэ хийдэд шавилан суусан бэ, Цагаан суварганы хийдэд?

Хайвжунай: Би чинь одоо ...1932 он хүртэл байсан.

Гантулга: Тэгэхэд одоо та хэдтэй байсан бэ?

Хайвжунай: Үгүй би чинь одоо ес, аравтай л байсан байх.

Гантулга: Хэдэн наснаасаа шавилж суусан?

Хайвжунай: Дөрвөн наснаасаа л эхэлж суугаад л, тэгээд л эхлээд маань мэгзэмээ уншиж сурсан байх даа. Тэгээд жинхэнэ ном заалгаад эхэлсэн нь бол сүүлийн гурван жил тэр манай хот хүрээнд байж байгаад... Дашчоймбол дацан, тэрний Гүрмээ унзад гэж, Ёндон унзад гэдэг хүн...

Гантулга: Шавь ороод...?

Хайвжунай: Тэндээс энд ирээд тэгээд тэр өөрийн орон байр, гэр орон мал гэж байдаггүй ч хүн байсан юм уу... Манай аав нэлээн тийм зальтай, номтой юмтай тийм хүн. Тэгээд энэ хурлын нярав байж байгаад зайсан болсон юм.

Гантулга: Аав чинь үү?

Хайвжунай: Тэр манай аав. Тэгээд тэр аав л гэр барьж өгөөд, тэр Ёндон унзадад. Тэгээд тэр өөрийнхөө зээ дүү Ёндонжунай гэдгийг надтай, одоо өөрийнх нь хүү нь юм л даа би Хайвжунай нь. Бид хоёрыг сурга гээд, гэр барьж өгөөд, хоол ундыг чинь бүгдийг нь даана гээд тэгээд ингэсэн айл болгочихсон. Тэгээд л бид хоёрт одоо ном заасан. Тэгээд л ном заалгаж, гурван жил болж тэгээд л бага цогчин гэж ордог байсан. Их цогчин бас хорин хэдэн ном, тэгээд л магтаал дөчөөд ном...

Гантулга: Гучин хоёр магтаал?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хайвжунай: Тэгээд тэрнийг чинь төгссөн. Тэнхээгээрээ л уншдаг байсан. Тэгээд л...

Гантулга: Арван хангал?

Хайвжунай: Тэгээд л хангал руу ороод л нэг за даа... Тэгээд л нөгөө ямандаг, хам, гомбо эхэлж хоёр гурав дөрвөөд ном байна л даа, үзээд л. Тэгж байтал тэгээд л нөгөө багшийг минь барьж аваад л, тэгээд л явсан. Тэгээд ерөөсөө мэдэхгүй ээ, тэр нэг сар болсон уу үгүй юу тэндээ хороогдсон шиг байгаа юм. Аймаг дээр...

Гантулга: Хэлмэгдлийн үед?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Энэ Цагаан суваргыг хэзээ хэн байгуулсан хэдий үед байгуулсан талаар та мэдэх үү?

Хайвжунай: Энэ би сайн мэдэхгүй байна. Зүгээр хүн амьтнаас асуугаад би нэг тийм нэг, уул нь тэр Улаанбаатарт байгаа Мамбадацангийн хамба Нацагдорж нэг тийм маягтархуу юм...

Гантулга: Бөглүүлж авсан?

Хайвжунай: Ирсэн юм. Өнөөхийг нь нөхөөд л, тэгээд энэ хавийн хурлуудын тухай. Тэрэн дээр л нэг он сар дунджаар биччихсэн юм. Одоо хэлэх юм алга л даа, надад.

Гантулга: Энэ Цагаан суварганы хийд хуучин засаг захиргааныхаа нэгжээр аль аймгийн аль хошуу гэж байсан бэ?

Хайвжунай: Энэ чинь Сайн ноён хан аймгийн Балдан засгийн хошуу.

Гантулга: Юу гэдэг газар вэ?

Хайвжунай: Сайн шанд.

Гантулга: Сайншанд гэдэг газар уу?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Эргэн тойрон уул усаар нь нэрлэвэл? Ямар уулын ар өвөр дээр?

Хайвжунай: Шиврээ уулын зүүн үзүүр өвөр дээр байгаа юм.

Гантулга: Энэ зүүн баруун талд нь бол?

Хайвжунай: Аа тэгээд л тэр баруун талд нь Шиврээ байгаа юм. Тэрнээс цаашаа тэгээд л ...юу.

Гантулга: Энэ зүүн талд нь ямар уул байна?

Хайвжунай: Зүүн талд нь Номгон, Зөөлөн гэж хоёр уул байна.

Гантулга: Урд талд нь?

Хайвжунай: Урд талд нь бол тэр говийг гаталчихаад Ноён уул. Ноён богд.

Гантулга: Хойд талаараа?

Хайвжунай: Хойд талаараа ер нь орй уул байхгүй ээ. Энэ хойд говь гаталж байж Арц Богд.

Гантулга: Тэр суварга барьчихсан овоо чинь бас нэртэй юу, нэргүй юу?

Хайвжунай: Яг энэ... нэргүй ээ.

Гантулга: Цаана нь бас нэг толгой байна лээ?

Хайвжунай: За тэр чинь Бунхан шар гэдэг юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэр дээрээ маанийн үсэгтэй?

Хайвжунай: Тэр чинь Бунхан шар. Тэр хурал байж байхаар юуны бунхан байсан юм, тэр нэг бунхантай. Бас жилд нэг тахичихдаг, тийм байсан юм. Тэр тойроод нэг дөрвөн овоо байгаа юм. Тэр чинь нэг нь. Урд талд Хөх овоо гэж байгаа юм. Хйод талд Шар овоо гэж байгаа юм. Энэ баруун хойд талд, зүүн хойд талд Хар овоо гэж байгаа юм. Тэр Хар овоог нь тахидаг байсан юм уу үгүй юм ү, энэ гурвыг нь тэр наад жасууддаа хувааж өгөөд таахиулдаг байсан. За тэгээд жинхэнэ тэр өөрөө... цогчин жас нь энэ Сэврэй уул гээд...

Гантулга: Энэ хайрхнаа тахидаг?

Хайвжунай: Энэ хайрхнаа тахидаг байсан.

Гантулга: Тэр жасууд нь болохоор ямар ямар овоогоо тахидаг байсан юм бэ?

Хайвжунай: Тэр жасууд нь болохоор харин тэр энэ Шар овоо, Хөх овоо, тэр Бунхан Шар тэд нарыг тахидаг байсан юм.

Гантулга: Жасуудыг нь нэрээр нь нэрлэвэл? Тийм юмны жас, цогчин жас гээд?

Хайвжунай: Өө тэр их том нь л тэр цогчин жас, за тэгээд л мамба жас, дүйнхор жас, за нэг нь жүд байл уу. Ийм нэг дөрвөн жас л байсан байх даа.

Гантулга: Одоо энэ Цагаан суварганы ойролцоо хорь гучин км- ч байдаг юм уу, эргэн тойрон энэ хошуу нутагтаа байгаа хурал хийдүүдийн талаар нэрлэвэл?

Хайвжунай: За одоо энэ чинь одоо яг эндээ нэрлэвэл... хойшоо бараг жаран км байх аа.

Гантулга: Болно оо болно.

Хайвжунай: Жаран км-т нөгөө юу байгаа юм... Дуган.

Гантулга: Аа мөн.

Хайвжунай: Дуган гол гэж ярьдаг юм. Тэгээд тэрнээс зүүн хойшоо бас нэг далаад км-т...

Гантулга: Хоолт?

Хайвжунай: Хоолтын маанийн хурал гэж байгаа юм. Өө эндээс яг зүүн тийшээ Цагаан дэрс гэдэг газар, за тэр Цагаан дэрсний хурал гэдэг зурхайн хурал. Тийм зурхайн хурал гэж эндээс нэг зуугаад км-т байна. Байсан юм билээ. Ийм л юм энэ эргэн тойрон.

Гантулга: Тэр баруун тийшээ бас Гоёот?

Хайвжунай: Аа тэр баруун тийшээ бол, одоо Гурвантэсийн нутагт байгаа юм. Тэр Нэмэхт, Нэмэхт уулын өвөр дээр Гоёот гэж байсан юм, Гоёот.

Гантулга: Энэ одоо сүм хийд нураагдахаас өмнө одоо Цагаан суварганы яг, байгаа байдлыг зурсан ч байдаг юм уу, одоо фото зураг юмаар авчихсан зурагны юм зураг байхгүй юу?

Хайвжунай: Байхгүй. Ер нь бол байхгүй ээ.

Гантулга: Байхгүй юу?

Хайвжунай: Байхгүй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ одоо засаг ноёных нь хошуу тамгын газар нь хаанаа аа байсан юм, тэнд тийм хурал хийд байсан юм уу, Хошуу хурал гээд...?

Хайвжунай: Өө тэр чинь байсан юм. Энэ Хошуу чинь энэ зүүнтээ Гурвансайханы наана энэ Дундсайханы өвөр Зүүнсайханы баруун үзүүр дээр хошуу төвлөрч байсан. Тэгээд л тэр чинь наашаагаа нүүгээд л Төхөмийн голд нэг байсан юм гэнэ лээ. Тэгээд тэр миний хэлдэг Цагаан дэрсний зурхайн хийд дээр чинь нэг төвлөрч байсан юм гэнэ лээ. Тамгын газар нэртэй.

Гантулга: Энэ Цагаан суварганы одоо цогчин дуган байсан гэж байна ш дээ?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Бас хээдн дацан байсан гэж байна?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Тэгээд эд нарын одоо гол шүтээн, гол ядам сахиусыг нэрлэвэл?

Хайвжунай: Ер нь дор дороо тэр ер нь мэдэхгүй. Тэр хурлын гол сахиус нь Дамдин сахиус гэж байдаг юм. Дамдин сахиус...

Гантулга: Гол шүтээн нь?

Хайвжунай: Шүтээн нь Дамдин сахиус л байсан.

Гантулга: Ядам нь?

Хайвжунай: Ядам нь одоо... Үгүй ээ Жанрайсаг л юм даа.

Гантулга: Сахиус нь?

Хайвжунай: Сахиус нь харин тэр Дамдин.

Гантулга: Гол бурхан шүтээн нь гэж бол байгаагүй юм уу? Том бурхан багш ч юм уу, Богд Зонхован энэ тэр гэж байсан уу?

Хайвжунай: Үгүй.

Гантулга: Одоо энэ бол шарын л хурал байсан уу?

Хайвжунай: Тэгсэн.

Гантулга: Өөр одоо урсгал чиглэлийн тийм юм бол байгаагүй?

Гантулга: Үгүй, байгаагүй.

Гантулга: Энэ хичнээн лам хуварга шавилан хүрж байсан бэ?

Хайвжунай: За нэг дээд тал нь нэг 45-50 хүрч байсан болов уу үгүй болов уу. Тэгээд нэг дунджаар ер нь дөчөөд лам байсан даа.

Гантулга: Энэ тухайн хошуу хурал нутгийн лам нар байсан уу, өөр хошуу нутгаас шавилан сууж байсан уу?

Хайвжунай: За бараг...

Гантулга: Өөр хүрээний Дашчоймбол эд нараас ирж байсан гээд хэлж байсан...?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хайвжунай: Үгүй ээ ер нь бараг нутгийн лам нар байсан.За гэхдээ тэр хойноос ирж байсан лам нар байсан л даа, цаашаах лам нар. Тэр миний багш байж байна. Тэр Гончигсум гээд, мөн энэ нутгийн сайнчойрын гэвш хүн байсан.

Гантулга: Аль хошуу нутгийн хурлын хүн байсан юм, тэр Гончигсум гэдэг нь?

Хайвжунай: Үгүй ээ харин энэ хурал дээр л ирж байсан. Уул нь бол хүрэн дээр л , Ганданд л байсан байх даа, тэр Гончигсумыг хаана байсныг мнь мэдэхгүй юм.

Гантулга: Өмнөө?

Хайвжунай: Үгүй тэр нутгийн л хүн ирж байснаас өөр тийм нутгаас байж байсан юм байхгүй ээ.

Гантулга: Тэгэхээр одоо энэ хошуу нутгийн залгаа, хошуу нутаг дотроо байгаа өөр хийдүүдээс, одоо энэ Дуганы хурал ч юм уу, Гоёотоос хүн ирж шавилан сууж байсан уу?

Хайвжунай: Өө харин тэр Дуганы хурал, тэр Гоёотоос ч гэсэн тэр үгүй нэг тэр хурал , цагийн хурлууд болно л доо.Тэрүүгээр ирж хурдаг л байсан.

Гантулга: Цагийн хурлаар л ?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Ерөөсөө энэ бол цагийн хуралтай л газар байсан юм уу, байнгын хуралгүй байсан юм уу?

Хайвжунай: Үгүй ер нь л цагийн хуралтай байсан.Тэгэхдээ одоо цогчин сахиусаа бол тогтмол өдөрт тахидаг нэг хэдэн хүн байгаад одоо ээлж ээлжээр тэгж тахидаг байсан.Тэрнээс биш тогтмол байгаагүй .Тэгээд л шавь нар ном энэ тэр үзэхэд чинь ерөөсөө намар орой хүрч ирээд л, өвөл жаал үзэж байгаад л тэгээд л хавар ногоо гарахаар яваад өгдөг. Ямар ч гэсэн лам нар нь ч гэсэн, шавь нар нь ч гэсэн тэгдэ эг л байсан.

Гантулга: Энэ хийдийн том эрдэмтэй лам нарыг нэр усаар нь яривал, хэргэм зэргээр нь?

Хайвжунай: За даа тэгээд л ер нь хамгийн дээд тал нь зурхайч багш гэж , Пүрэв зурхайч гэж овоо мэдлэгтэй тийм зурхайч хүн байсан.Мөн энэ хурлын ловон нэг хэд хоног байж л байсан байх.

Гантулга: Тэр Олз ловон гээд үү?

Хайвжунай: Үгүй ээ тэр Пүрэв зурхайч гэж.Тэгээд л тэрний дараагаар одоо манай ах Ням ловон гээд л байж байсан.Тэр Гүмбэндээ гурван жил явж ном үзсэн л гэсэн. Иймээ тиймээ тийм мяндаг тушаал юу ч байгаагүй байх аа.

Гантулга:Цол хэргэм?

Хайвжунай: Цол хэргэм одоо нэг их байгаагүй болов уу.Лав л одоо эндээ л ловон нэртэй.Тийм л хүн байсан, зүгээр нэг мүүхан эм барьчихна, зурхай үзчихнэ.

Гантулга: Мамба дацангийнх нь хүн юм уу?

Хайвжунай: Аан?

Гантулга: Аль дацандаа байсан хүн юм?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хайвжунай: Үгүй тэр чинь одоо мамба дацандаа, мамба дацанд байсан.Тэгээд л зүгээр энд байж байгаа тэр Овоотын хийд дээр байж байдаг, ер нь манай тэр улсад бараг нэг хоёрдугаарт ордог гэнэ лээ.Аграмба багш, Сандаа аграмба гэж нэг хүн байсан юм гэнэ лээ.Энэ дээр хүрч ирээд л , нэг гэртэй.Тэгээд л алга болчихдог. Тэгж байгаад л нэг ирээд л , нэг хоёр сар болж байгаад л явчихдаг.

Гантулга: Ном заадаг байсан уу?

Хайвжунай: Заадаг байсан. Аграмба багш, Сандаа аграмба гээд.

Гантулга: Шар тарнийн л ном заах уу?

Хайвжунай: Тэгнэ. Настай л хүн.

Гантулга: Төвд лам нар энэ тэр байсан уу, ирж очиж байсан уу?

Хайвжунай: За ер нь миний мэдэхийн бараг байхгүй.

Гантулга: Энэ гэлэн сахилтай хүн бол байсан уу, танай хурал дээр?

Хайвжунай: Байсан.

Гантулга: Хэн хэн гэж хичнээн хүн?

Хайвжунай: Өө тэр гэлэн сахилтай чинь ер нь нэлээн юм байсан шүү.Ер нь тэгээд тл тэр дээд талын том ..Үгүй ер нь гэлэн нэлээн олон байсан.Ер нь тэр ухаанда дөчөөд ламтай гэхээр хориод нь лав гэлэн байсан байх.

Гантулга: Энэ одоо зурхайн дацан, дүйнхор дацан, мамбын дацан гээд хэдэн дацан байсан гэж байна ш дээ?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Одоо тэгвэл мамба дацан гэхэд л нэртэй том эмч, маарамба хүн байсан уу?

Хайвжунай: Үгүй , тусгай тийм юм байгаагүй.

Гантулга: Пүрэв зурхайч гээд л алдартай зурхайч?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Хуучны чинь энэ зурхайч маарамбууд чинь нэг л хүн байсан уу, зурхайгаа ч хийчихдэг, маарамбаа ч хийчихдэг? Зүгээр тус тусд нь..?

Хайвжунай: Тэгж ер нь, энд байгаа лам нар бараг тийм байсан.Эм ч ч хийнэ...

Гантулга: Зурхай ч зурах уу?

Хайвжунай: Зурхай ч зурна, хуралдаа ч зурна.

Гантулга: Гүрэм заслаа ч хийчихнэ?

Хайвжунай: Тийм , гүрэм заслаа ч хийчихнэ.Тэгдэг л улсууд байсан.

Гантулга: Таныг одоо энэ хуралд хурж байхад чинь Цагаан суварганы хийдийн лам нарыг дээд мяндаг тушаалаар нь ингээд ярих юм бол одоо хамба лам нь тэр, цорж нь тэр гээд, ловон нь тэр, гэсгйү нь тэр, унзад нь тэр, даа лам нь тэр, дамал нярав нь тэр тэр гэж нэртэй хүн байсан гэж нэрлэвэл? Тус бүрээр нь?

Хайвжунай: Үгүй ээ тэгээд л одоо ухаандаа нэг хүний юуг хэлэхэд л ...Ухаандаа ловон нь тэр Ням ловон, манай ах.Тэгээд л тэр унзад нь манай багш Ёндон унзад. Тэгээд л тэр нэг Найдан гэж ярьдаг байсан юм даа, тэд нар

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

чинь, тэр энэ Чимэд. Найдан лам гээд.Одоо заримыг нь тэр, найдан лам гээд алийг нь хэлж байлаа. Манжид энэ тэр гээд л тэгдэг юм.Дэмчиг манжид гээд л бас нэг лам байсан юм.

Гантулга: Гэсгүй их байсан уу?

Хайвжунай: Гэсгүй ч наагуур нь Гончигсүрэн гэсгүй, Дэнзэн гэсгүй...

Гантулга: Даа лам гэхээрээ?

Хайвжунай: Үгүй ээ даа лам гэхээр би мэдэхгүй юм. Байсан юм байхгүй байх аа.

Гантулга: Хурлын даамал нярав энэ тэр гэж байсан уу, цогчин даамал энэ тэр гээд л ...?

Хайвжунай: Байна аа.Тэгээд харин тэр хурлын нярав хйиж байгаад зайсан гэж нэг юм хийдэг байсан юм.Тэр одоо ухаандаа тэр алба хийдэг хүн нь зайсан хийж байсан байгаа юм.Тэр данс мансыг нь барьдаг хүн.

Гантулга: Таны аав?

Хайвжунай: Тийм манай аав Дорж гэж хүн байсан юм.

Гантулга: Хамба лам энэ тэр гэж бол байгаагүй юм байна тийм ээ?

Хайвжунай: Байгаагүй ээ.

Гантулга: Хамгийн дээд цол нь л ловон?

Хайвжунай: Тийм, тэр аграмба багш. Тэр Сандаа аграмба гэдэг чинь явдлын хүн болоод л тэгдэг байсан байлгүй, тэр чинь одоо яг энэ хурлын эзэн биш.Зүгээр л тэр...

Гантулга: Ирж ном заадаг?

Хайвжунай: Ирж ном заадаг хүн байсан.

Гантулга: Замын багш байсан?

Хайвжунай: Тийм л байсан.

Гантулга: Та ном заалгаж байсан уу?

Хайвжунай: Өө заалгаж л байсан л даа. Зүгээр жинхэнэ миний тэр багш Ёндон унзад.

Гантулга: Энэ Цагаан суварганы хурал дээр чинь Мамба дацан байсан, Жүд байсан, Дүйнхор байсан гэж байгаа тийм ээ?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Имй гурван л дацан байсан уу?

Хайвжунай: Тийм, тэгээд л нөгөө цогчингийг чинь юу гэлээ дээ. Ерөнхий тэр...

Гантулга: Цогчин дуган?

Хайвжунай: Тийм, цогчин дуган, цогчин...

Гантулга: Цогчин хурал энэ тэр?

Хайвжунай: Тийм, цогчин хурал, цогчин жас энэ тэр гээд.

Гантулга: Сүм гэхээр одоо жишээ нь Жанрайсагийн сүм, Майдрын сүм энэ тэр гээд байсан уу?

Хайвжунай: Үгүй.Хоёрхон дуган байсан, Их бага дуган гээд.Тийм тэгээд ухаандаа Хангал юуг нь Их дугандаа хурдаг, цогчингийг нь Бага дугандаа хурдаг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Одоо нөгөө дугандаа, голд нь одоо үүдэн дээр Төвдөөр нэр пайз тийм нэртэй дуган, дацангаа бол тийм нэртэй дацан гэж тус тусдаа тийм байгаагүй юу?

Хайвжунай: Үгүй, байгаагүй.

Гантулга: Гүрэм дором гэдэг юм уу, тийм дацан байсан уу? Дацан хурал?

Хайвжунай: Үгүй, ерөөсөө тийм юм байхгүй. Ердөөл тэр байж байгаа улсууд л дором гүрэм хийнэ л дээ.

Гантулга: Жишээлбэл ямар ямар гүрэм хийдэг байсан бэ?

Хайвжунай: Үгүй ээ тэрийг чинь одоо тэгээд сайн мэдэхгүй юм. Нэлээн сүрхий юмнууд шид гаргана...

Гантулга: Жагшээ?

Хайвжунай: Аан?

Гантулга: Жагшээ уншдаг байсан уу?

Хайвжунай: Юу?

Гантулга: Жагшээ, ширмэн түдэг?

Хайвжунай: Хийдэг байсан байх шүү.

Гантулга: Суварга бол хоёр суварга байсан юм байна тийм ээ?

Хайвжунай: Тэгсэн.

Гантулга: Дээр доороо?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Тэр толгой дээр нэг, доор нь нэг?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Доор нь түрүү нэг засаг даргын орлогч гээд нэг хүн байна.Тэр тэгсэн чинь доороо хоёр суварга байсан, дээр нь нэг суварга байсан гэж байна лээ. Манай аав тэгж байсан гээд.Тэгээд би танаас тодруулж асууч гэж байсан юм. Хоёр суварга байсан юм байна, тэгвэл тийм ээ?

Хайвжунай: Хоёр байсан л даа.Тэр доор, дээдх нь тэр орой дээр нь байгаа, тэндээс Жүгдэл дэмдэлийн суварга гээд байсан л юм гэнэ лээ.

Гантулга: Доод талынх нь?

Хайвжунай: Доод талынх нь Намжил суварга гэж.Тэр манай ах, тэр Ням ловон л бариулсан юм гэнэ лээ.

Гантулга: Ном барладг тийм барын ву байгаагүй юу?

Хайвжунай: Байгаагүй.

Гантулга: Бархан энэ тэр?

Хайвжунай: Ер байгаагүй шүү.

Гантулга: Одоо гол дуганд бол судар ном их байсан байх даа, ганжуур данжуураас авахуулаад л ?

Хайвжунай: Аа бүх юм байсан.Ганжуур данжуур байсн. Үгүй ээ судар ном их байсан.

Гантулга: Төвдөөрөө юу, Монголоороо юу, дан Төвдөөрөө юу?

Хайвжунай: Дан даа Төвдөөрөө байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Ганжуур хурдаг байсан уу?

Хайвжунай: Хурдаг байсан.

Гантулга: Ер нь цагийн хурлууд нь ямар ямар хурал хурдаг байсан бэ?

Хайвжунай: За тэр нэг, за яахав Хайлан хийнэ. Мамба бас нэг цагтай, мамба хурна.

Гантулга: Манал хурна?

Хайвжунай: Тийм манал хурна.

Гантулга: Эх манал?

Хайвжунай: Эх манал. Аа юу хурна...

Гантулга: Гүр хурдаг байсан уу?

Хайвжунай: Аа хурна. Гүнгэрийг харин гайгүй хурдаг байсан юм.

Гантулга: Хайлан эд нараа одоо тэдэн сарын гэдэг юм уу, зуны эхэн сарын гэдэг ч юм уу хугацаатай байсан уу?

Хайвжунай: Тийм хугацаатай байсан.

Гантулга: Хайлангаа одоо ингээд жилийн тойргоороо ярихад, хаврын эхэн сараасаа эхлээд хурлаа яривал?

Ерөөлөө хурна гээд л ?

Хайвжунай: Тэгнэ. Дандаа тэгж байна.

Гантулга: Тэгээд ингээд жилээ тойруулаад, Чоймбор жав гуайн ерөөлөөр юу хурдаг байсан бэ?

Хайвжунай: Аан?

Гантулга: Чоймбор жав гуайн ерөөлөөр юу хурдаг байсан бэ?

Хайвжунай: Үгүй энэ чинь одоо...

Гантулга: Цагаан сар?

Хайвжунай: Цагаан сардаа одоо цагаан сарынхаа хойхно л , энэ яинь одоо магтаал гээд л нэг арван хэдэн ном байдаг шүү дээ, хориод ном. Үгүй тэрнийг л уншаад байна.

Гантулга: Майдар эргэдэг байсан уу?

Хайвжунай: Эргэдэг байсан.

Гантулга: Хэдийд эргэдэг байсан ?

Хайвжунай: Үгүй ээ энэ зуны эхэн сарын шинийн найманд байсан уу.

Гантулга: Тэгээд л ерөөл өргөж хурчихаад л дараа нь ямар номо хурах вэ, жаил тойронгоор нь яривал, хаврын тэргүүн сарын гээд л?

Хайвжунай: Хаврын тэргүүнд тэр ерөөлөө хурчихна. Тэгээд байтал тэгээд л хайлан хурдаг байсан байх.

Гантулга: Аан зүн?

Хайвжунай: Тэгээд л ...

Гантулга: Тэгээд л намар?

Хайвжунай: Намар ч нэг хурал хурдаг л байсан л даа. Тэгээд ямрыг нь хурж байсныг нь мэдэхгүй юм , тэр чинь тэгээд...

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Зулын хорин тавнаар?

Хайвжунай: Зулын хорин таванд, хурлаа л хийнэ. Яахав тэр чинь тэгээд ямар юу ч үзэж байсан билээ, ямар юм...

Гантулга: Салаавын хорин хоёрноор?

Хайвжунай: Аан?

Гантулга: Салаавын дүйчэн хорин хоёрон гэж байдаг ш дээ? Есөн сарын хорин хоёрон?

Хайвжунай: Есөн сарын хорин хоёрноор үгүй бас нэг лам нар цуглаад л хурал хурдаг байсан. Тэр чинь ямар хаурал хурдаг байсан юм, мэдэхгүй. Ер нь жинхэнэ болвол юунаас өмнө, өвлийн адаг сарын эхээр цугладаг байсан байх даа. Тэгээд л юугаа бага цогчингоо, цогчингоо нэг дугандаа хураад л, хангалаа нэг талдаа хураад л. Тэгээд л шинэлчихээд л, тэгээд л шинээс цаашаа магтаал хураад явчихна.

Гантулга: Ерөөл магтаалаа хурна?

Хайвжунай: Тэгнэ. Тэгээд л арванд, үгүй ээ аравны хурал гээд л өдөр шөнө хоёр нэг хурал хурдаг байсан байх. Одоо Гомбо л, лам Гомбо л уншаад байдаг байсан санагдаад байх юм

Гантулга: Цогчин уншлаганд одоо тийм тийм ном уншдаг гээд нэр нэрээр нь нэрлэвэл?

Хайвжунай: Ээ тэрийг чинь одоо нэрийг нь хэлж чадахгүй нь, ер нь бол эхлээд л одоо үгүй ер нь энэ л сангаа тавиад л, дашцэрэв юунаасаа эхлээд л үгүй ингээд л уншдаг байсан даа.

Гантулга: Тэгээд л цогчин уншлага гээд л цаашаагаа...?

Хайвжнай: Тийм.

Гантулга: Залгаад л одоо цогчин уншлагандаа тийм тийм ном уншина гээд?

Хайвжунай: Жилд болдог тэр том хурал чинь л одоо жилд хоёр л болж байгаа юм. Одоо тэр цагийн хурал гээд, тэр том хоёр зэрэг ч гэлээ л уншдаг. Зун нэг болоод, тэгээд нэг майдар эргээд тардаг. Өвөл нэг болоод тэгээд цагаан сар эхлээд нэг том хурал нь тардаг. Тэгээд бага хурал нь эхлээд явдаг байсан юм даа.

Гантулга: Цагаан сараараа нэг хурчихдаг?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Тэгээд зундаа хэдэн сард тэр майдар энэ тэр нь эргэх үү?

Хайвжунай: Шиний найманд л, зуны эхэн сарын шинийн найманд л яадаг шүү. Тэгэхлээр бас нэг хориод хоног хурж байх шиг л байдаг байсан.

Гантулга: Цам энэ тэр гарч байсан үү?

Хайвжунай: Гарсан, гардаг байсан. Цам энэ тэр чинь одоо тэг майдраа эргэхэд нэг гарч байсан.

Гантулга: Жилдээ нэг л гарах үү?

Хайвжунай: Нэг л гарна.

Гантулга: Цам, майдар нь үү?

Хайвжунай: Тэгнэ.

Гантулга: Майдар эргэнэ гээд л ?

Хайвжунай: Тэгнэ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Хэдэн өдөр эргэдэг байсан юм бэ?

Хайвжунай: Өө ганц л өдөр эргэнэ.

Гантулга: Сүсэгтэн олон их цугладаг байсан уу?

Хайвжунай: Өө цуглана, ер нь ч хүн цөөнтэй газар юм даа, тэгээд ер нь байгаа улсууд нь цуглана шүү.

Гантулга: Майдар эргэхэд тэр майдрын цам гэж гардаг байсан уу, эсвэл өөр?

Хайвжунай: Тэгдэг байсан.

Гантулга: Аа майдрын цам гэж гарна?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Цамынх нь одоо тийм бүжиг, тэр багууд...?

Хайвжунай: Тийм юм байсан.

Гантулга: Дэг нь одоо хаанахын дэгээр явдаг байсан, ямар дэгээр? Хүрээ дэг байсан юм уцу, өөр газрын дэг?

Хайвжунай: Ээ тэр хүрээ дэг байсан байх.

Гантулга: Хэдий үеэс цам гардаг болсныг нь мэдэх болов уу?

Хайвжунай: Цаг нь уу?

Гантулга: Тийм.

Хайвжунай: Харин зуны эхэн сарын...

Гантулга: Үгүй ээ биш нөгөө энэ хийдэд ер нь анх хэзээнээс эхэлж цам гаргадаг болсон юм?

Хайвжунай: Ээ мэдэхгүй, тэрийг мэдэхгүй шүү.

Гантулга: Ер нь тэгээд л таныг хурал хаатлаа л цам нь гарж л байсан уу?

Хайвжунай: Гарч л байсан.

Гантулга: Цамын дүрүүдээс нь хэлвэл? Хичнээн баг гардаг байсан, тиймтийм юмны дүрүүд байсан гээд?

Хайвжунай: Үгүй ээ, ер нь амьдын Жамсрангууд л гардаг байсан байгаа юм. Чойжээ гуай.

Гантулга: Дамдин Чойжээ юу?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Аан за өөр? Цагаан өвгөн?

Хайвжунай: Гардаг байсан.

Гантулга: Тэгээд л нөгөө нэг өөр юу юунууд гардаг юм ер нь?

Хайвжунай: Цагаан өвгөн гардаг байсан.

Гантулга: Шанаг гэжс гарадг байсан уу?

Хайвжунай: Аан?

Гантулга: Шанаг?

Хайвжунай: Үгүй ээ тэр чинь ямар юм байдаг билээ?

Гантулга: Нөгөө хар малгай өмсчихөөд гардаг?

Хайвжунай: Үгүй ээ тэр чинь нэг хөх малгай өмсчихөөд гардаг, таягтай юмыг чинь ямар юм гэдэг билээ дээ...

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Ганжуур эргэх ёслол болдог байсан уу?

Хайвжунай: Ганжуур эргэдэг байсан.

Гантулга: Ганжуураа одоо хүрээгээ тойроод эргэчихдэг байсан уу, хошуу нутгаараа авч явдаг байсан уу?

Хайвжунай: Энэ нэг хоёр тэмээнд ачаад, тэгээд л нэг дөрвөн лам яваад л уншдаг.Тэгээд л энэ баруун энгэрээд яваад л, энэ баруун сэврэй уулаа...

Гантулга: Эргээд?

Хайвжунай: Нэг эргээд л ирдэг байсан.

Гантулга: Тэгээд л эргээд хүрээд ирдэг байсан уу?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Ганжуураа хэдэн сард эргэдэг байсан, жилдээ нэг удаа л эргэдэг байсан уу?

Хайвжунай: Зун цагт одоо хэдийд эргэж байсан юм, чухам.Долоон сард л хойно зун эргэдэг байсан.Жилд нэг л эргэнэ.

Гантулга: Хэдэн хоногоор явдаг байсан юм бол, дунджаар бодвол? Багцаагаар...?

Хайвжунай:Үгүй ээ энэ чинь нэг хоёр хоног л болно.

Гантулга: Тэр ганжуур эргэхээр тушаагдсан дөрвөн ламаас өөр лам явахгүй юу?

Хайвжунай: Үгүй.

Гантулга: Оролцохгүй?

Хайвжунай: Тэгнэ.

Гантулга: Ганжуураас өөр ямар ном эргүүлдэг байсан, хүрээ хийдээ ч юм уу, хошуу нутгаа ингээд уул муулаа тойроод эргэвэл, ганжуураас өөр ном судар эргүүлж байсан уу?

Хайвжунай: Үгүй.

Гантулга: Өөр судраа бол эргүүлдэггүй байсан уу?

Хайвжунай: Үгүй.

Гантулга: Тэмээнд л ачаад явахаас биш, өөр тэрэг мэргэнд...?

Хайвжунай: Үгүй, тэмээнд л ачаад л ...

Гантулга: Цагаан сарын хурлын тухай жаахан дэлгэрэнгүй ярьж өгөхгүй юу? Тэдэн лам сор залах гэдэг юм уу, хуучин номын хурал гээд?

Хайвжунай: Үгүй ээ тэр чинь энэ чинь одоо...

Гантулга: Ерөөл энэ тэр хурдаг байсан уу?

Хайвжунай: Цагаан сарын хурлаар юуны хурал...

Гантулга: Битүүний хурал гэж байх уу?

Хайвжунай: Битүүнээс өмнө нэг арван хоёр хоног байсан юм уу...

Гантулга: Өмнө үү?

Хайвжунйа: Тийм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Арван хоёр хоногийн өмнө?

Хайвжунай: Өмнө. Тэгэхлээр тэр хоёр дуганд нь хангал догшид хураад байдаг. Аа нэгэнд нь одоо цогчин уншаад байдаг.Одоо бага лам нар нь тэр юу...

Гантулга: Цогчингоо уншдаг?

Хайвжунай: Цогчингоо уншаад, их өвгөн тийм өвгөн...

Гантулга: Хуучин настангууд нь?

Хайвжунай: Тэр настангууд нь хүүхдүүдтэйгээ тэр цогчингоо уншаад л ...Тэгээд л нэг жаахан уншлагатай залуухан лам нар том оам нар нь юугаа уншаад л ...

Гантулга: Хангалаа уншаад л ?

Хайвжунай: Хангалаа уншаад л.Ингээд л арван хэд хоног яачихаад л , тэгж хүрж байгаад л тэгээд л битүүний орой , биш ээ хорин есөнд сороо залаад л .Тэгээд л сор залчихаад л битүүнд нэг шөнө лхам...

Гантулга: Цэдэр Лхам?

Хайвжунай: Тийм , цэдэр лхам шөнө уншиж хоноод л .Тэгээд л өглөө нь цуглаж өглөө нь тэгээд л нэг тарчихаад л.Тэгээд л дараа нь цуглаж ...

Гантулга: Золгоно?

Хайвжунай: Золгочихоод л ...

Гантулга: Тэгээд л ерөөлөө?

Хайвжунай:Тэгээд л маргааш нь хэзээ ч билээ дээ, нэг хоногийн дараа байх аа даа.Тэгээд л ерөөл эхлээд л уншдаг.Тэгээд арваад хоног уншдаг байсан байх.

Гантулга: Шинийн арван таван хүртэл?

Хайвжунай: Тийм, үгүй ээ тэгээд тэр дундаа ч байсан билүү, тэр чинь яасан билээ. Энэ арванд л нэг аравны хурал нэртэй...шөнийн турш л нэг ламаа гомбоо юүмбээ ерэн та еэ, жисан чойр самба дүши, дамжи жам марчи сүмбэ еэ...

Гантулга: Гүржид, Гомбын гүржид?

Хайвжунай: Тийм, энийг нэг бүтэн шөнө ухаандаа тэр дацан дацангаараа цуглаад, шөнө бүтэн шөнө уншдаг, нэг тийм байсан.

Гантулга: Энэ дүйчэн өдрийн хурал, цагийн хурлуудаар, бурхан багшийн дүйчэн өдрөөр тийм ном уншина, Богд ламын дүйчэн өдрөөр тийм ном хурна гэж байсан уу, ялгаатай?

Хайвжунай:Үгүй ээ ер нь байсан байх. Би тэрийг сайн санахгүй юм.Тийм юм байсан.

Гантулга. Хайлан хурдаг байсан гэж байсан тийм ээ?

Хайвжунай: Тэгсэн.

Гантулга: Тэр хайланд хичнээн лам ордог байсан бол?

Хайвжунай: За тэр чинь цөөхөн шүү л юм байсан байх шүү.Ер нь нэг дээд тал нь тэгээд л хориод юм байсан байх.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэрэн дотор нь бол тэгээд гэлэн сахилтай хүн голцож байх уу, зүгээр хамаагүй байх уу?

Хайвжунай: Аа заавал гэлэн, зарим нэг гэцэл ордог байсан уу яасан.

Гантулга : Гэлэн гэцэл улсууд л ?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Нүгнээ гэж тийм зан үйл хийдэг байсан уу?

Хайвжунай: Хийдэг байсан.

Гантулга: Тэрний талаар жаахан дэлгэрүүлж яриач?

Хайвжунй: За ер нь дэлгэрүүлж чадахгүй юм байна .Ер нь нүгнээ хурж байсан л гэдэг юм .Тэнд л нэг хүүхэд нүгнээ хурж байгаа юм гээд л тэгж ярьдаг.Тэрнийг чинь тэгээд л ер нь сайн мэдэхгүй юм.Нүгнээ хурж л байдаг байсан.

Гантулга: Нүгнээгээс гадлна аравнай өргөх барих гээд л янз бүрийн тийм зан үйлийн хурал, чог могой янз бүрийн янз бүрийн хурал хурдаг байсан уу?

Хайвжунай: Үгүй ер нь тэр чинь тэгээд л албаар л , жилд тийм тогтмол юм байхгүй. Үе үе нэг тийм хурал хурдаг л байсан.

Гантулга:Үе үе л?

Хайвжунйа: Тийм.

Гантулга: Том лам нар ирж?

Хайвжунай: Том лам нар ирдэг юмуу тэр тийм энэ тэндээсээ аврал энэ тэр буулгадаг байсан юм уу яасан юм.Үе үе л хурдаг байсан.

Гантулга: Тэр үеэрээ ингэж наадам энэ тэр хийж өргөн тэмдэглэх үү, зүгээр нэг...?

Хайвжунай: За даа тэр ер нь үгүй байх аа. Майдар эргэхэд л нэг заавал нэг наадам хийж морь уралдаж бөх барилдаж тэгдэг байсан.Тэрнээс уртаар тэгж өөр нэг наадам хийдэггүй байсан.

Гантулга: Та бол энэ дацан энэ тэрт сууж ном үзээгүй юм байна, тийм ээ?

Хайвжунай: Үгүй ээ.

Гантулга: Тэд нарын уншлага хурал, жилийн хурал номын талаар хэлэх юм бол? Дацангуудын талаар одоо дэлгэрэнгүй?

Хайвжунай: Үгүй ээ тэр дацангуудыг чинь уг нь юу ч мэдэхгүй л дээ.Уг нь мамбад сууж л байсан байх юм.Тэгээд яахав дээ тэгээд л жилийн хуралд нь оролцоно.

Гантулга: Тэр мэрийг нь бол одоо дэлгэрэнгүй санах юм бол?

Хайвжунай: Байхгүй, алга аа ер нь алга.

Гантулга: Одоо тэгээд цогчин дуган, их бага цогчин дуган дацангууд байсан гэж байна.Эд нар одоо модон дуган байсан уу, шавар, зөн?

Хайвжунай: Дан шавар.Шавар байшин, дандаа шавар.

Гантулга: Хэлбэр дүрс нь?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хайвжунай: Үгүй ээ хэлбэр дүрс нь одоо...

Гантулга: Дөрвөлжин?

Хайвжунай: Дөрвөлжин, дандаа дөрвлөлжин.

Гантулга: Давхар байсан уу, адн нэг давхар?

Хайвжунай: Дандаа дан.Тэгээд нэг дуган л дээрээ асартай, жаал дөрвөлжин. Тэр дуган нь давхар болохоор одоо мэдэхгүй юм.Нэг асартай л юм байдаг байсан.

Гантулга: Ер нь хэлбэр галбираар нь яривал, монгол маягийн гэж ярих уу, хятад маягийн гэх үү, Төвд маягийн гэх үү? Дугангуудын хэлбэр галбир хийцийг нь яривал?

Хайвжунай: Үгүй ер нь одоо Төвд маягийн л юм уу даа.Өвөрмонгол.Одоо манай энд байж байсан тэр дуган л...Өвөрмонголд эзний гол, далайн хөв энэ тэр чинь тэр манай энд байсан дуган л байх юм.

Гантулга: Адилхан байна уу?

Хайвжунай: Адилхан байх юм.

Гантулга: Дээвэр нь бол алтан ганжир энэ тэртэй байсан уу? Ганжирууд нь?

Хайвжунай: Үгүй, тийм алтан ганжир юм байгаагүй.Үгүй ээ одоо энэ...ваар.

Гантулга: Вааран уу?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Гадуураа ингээд янз бүрийн өнгө будаг тавьсан байсан уу, туургаар нь ч гэдэг юм уу? Дуган дацангуудынх нь гадна тал нь будагтай байсан уу, зүгээр тэр тоосгоныхоо өнгөөр байсан уу?

Хайвжунай: Тоосгоныхоо өнгөөр байсан.Зүгээр нэг шохойдсог л байдаг байсан байх.

Гантулга: Тэгээд гол дуган нь энд байсан гээд ингээд ярихад бол цаасан дээр ингээд зурахад, за энэнээс нь энүүхэн талд нь бага дуган нь байсан, цогчин нь энүүгээрээ байсан, лам нарын байр нь энүүгээрээ байсан гээд хүүлээд явал та яг нарийн хэлэх үү? Аман зураг, аа тэгэх юм бол ингээд бүдүүвч зураг хийх гээд байгаа юм?

Хайвжунай: За нэг хэлнэ дээ.

Гантулга: Тэрийг нэг хэлүүлж авъя тэгвэл.За мамба дацан гээд байна, тэрэнд шалгалт шүүлэг өгч зэрэг дэв авдаг байсан уу? Дамжаа энэ тэр барьж?

Хайвжунай: Тэр ер нь үгүй байсан байх. Энд ерөөсөө тэр яагаагүй.Эндээс чинь тэр ерөөсөө гавж, мавж болох хэрэв тийм юм гарвал тэр Байшинтын хийд руугаа явдаг.

Гантулга: Аан Байшинтын хийд рүү явдаг?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Хэдий хугацаатай явдаг байсан , явбал ер нь?

Хайвжунай: Аа мэдэхгүй.

Гантулга: Тэгж явж, дамжаа барьсан лам нар хичнээн байсан, таны үед бол, яг таны байж байх үед бол? Байшинтын хийд ч юм уу, өөр энэ Дарь ламын хийд ч юм уу, том хийдүүд рүү явж дамжаа мамжаа брьж, цол хамгаалчихаад ирчихээд буцаж ирж байсан тийм?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хайвжунай: За миний үед бол нэг гурав, дөрөв л байгаа юм уу даа.

Гантулга: За за нэрлэвэл, нэрээр нь?

Хайвжунай: За нэрлэвэл одоо...за тэр манай ах Ням ловон нэг явж байсан.Аа Равжин гэж нэг явж байсан.За тэр Осор гэсэг гэж нэг явж байсан.

Гантулга: Ер нь Байшинтын хийд ч юм уу, тийм том хийдтэй бол дамжаа барих ч юм уу холбоотой л байсан юм байна, тийм ээ?

Хайвжунай: Тэгсэн.

Гантулга: Энэ ер нь танай хурал дээр бас сууж байсан, өөт хийдээс ирсэн лам нар одоо нөгөө их хурал, цагийн хурал эд нараа ирэх үү, том том?

Хайвжунай: Ирнэ ээ, ирээд л хуралдаж л байсан.Хойд талаас чинь Дуган голоос ирээд хуралдаж л байсан.Тэр баруунтаагаас юунаас ирээд, Гоёотоос ирээд л хуралддаг л байсан.

Гантулга: Энэ Байшинтын хурал чинь бол Чойр мойртой байсан уу?

Хайвжунай: Өө тэгсэн.

Гантулга: Олон дацантай байсан уу?

Хайвжунай: Олон дацантай байсанв

Гантулга:Тэрний исчаа энэ тэрийг нь бол та сайн мэдэхгүй юу?

Хайвжунай: Мэдэхгүй.

Гантулга: Хичнээн зиндаа барьдаг байж ю уяадаг байсан юм, зэрэг дэв...?

Хайвжунай: Өө мэдэхгүй, ер мэдэхгүй.

Гантулга: Одоо энэ Цагаан суварганы хийдтэй холбоотой байсан Дуганы хурал, Овоотын хурал эд нарын талаар жаахан дэлгэрэнгүй ярьж өгөөч? Тус бүр дээр нь тэгээдт өөрийнхөө дуулсан мэдсэн юм аа?

Хайвжунай: Өө том хурал байсан юм гэнэ лээ дээ, тэр лам нар их олонтой.Тэрэн дээр тэр аграмба багш за ерөнхийд нь удирддаг хүн байсан уу, аграмба багш ч их сүрхий хүн байсан даа.

Гантулга: Аграмба багш гэдэг нь ?

Хайвжунай: Тэр Сандаа аграмба гээд.Тэр чинь тэр юунд Байшинтын хийд дээр манай жасрай гэгээн гээдт суудаг байж билээ.Тэгээд тэрний багш байсан юм гэнэ лээ.Тэгэхлээр тэр чинь энэ, тэгээд л энэ хэдэн хурлуудаар явдаг, бартдаг.Тэр Жасрай гэгээд багшилдаг, сүрхий л хүн байсан шиг байгаа юм.Тэгэхээр олон лам нартай. Энэ Овоотод ч гэсэн сайн сайн лам нар байсан гэж л ярьдаг. Миний хэлж байгаа тэр Галсандаш мэтийн тийм хүнээс л дуулж байсан болохоос биш өөрөө явж үзэж байсан юм байхгүй л дээ.Харин энийг бол тэр Галсандаш их ухаантай, ер гарсан хүн гэхэд их ухаантай.Тэр болвол харин сайхан ярих байх.

Гантулга: Гоёотын хурлын тухайд яривал?

Хайвжунай: Гоёотын хурал болвол бас жоохон.

Гантулга: Хэдий орчим ламтай, хэдэн дугантай гээд?

Хайвжунай: Еэ нэг хориод ламтай л байсан юм гэнэ лээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Ер нь зүгээр голчилж тогтмол хурал хурчихдаг энэ тэр гээд?

Хайвжунай: Тогтмол хурал байхгүй ээ.

Гантулга: Цагшийн хурлуудтай?

Хайвжунай: Цагийн хурал нэг зах юм л хурчихдаг. Тэгээд хурлаа ч бас сайн яахгүй байх нь л дэ, тэр наашаа хүрч ирж энд хурдаг, тэр жаахан юм мэддэг улсууд нь...

Гантулга: Дуган хурлын тухайд бол?

Хайвжунай: Дуган чинь харин тэр цагийн хурал ч хурдаг, гайгүй чхэдэн лам нартай.

Гантулга: Тоог нь хэлвэл? Хэдий орчим?

Хайвжунай: Ээ харин бас л нэг дөчөөд орчим юм байсан байх.

Гантулга: Дуган дацангий нь яривал бас ямаршуу юу байсан бол?

Хайвжунай: Үгүй ээ ер нь тэрнийг бол мэдэхгүй юм аа.

Гантулга: Овоотын хурлын тухайд бол?

Хайвжунай: Овоотод ер нь олон дацантай юу байсан юм гэнэ лээ. Их сайн, сайхан хурал байдаг. Тэгээд тэрэн дээр чинь одоо эндээс их хүн ирдэг, цаанаас тэр Өвөрмонгол, тэндээс их хүн ирж суудаг, хурдаг тийм байсан юм гэнэ лээ.

Гантулга: Зөв зөв. За энэ Төвдийн хурлуудтай бол ямар нэгэн харилцаа холбоо байгаагүй юм байна тийм ээ?

Хайвжунай: Байгаагүй.

Гантулга: Тэндээс энэ Төвдөөс эргэл мөргөлөөр явж байна, Энэтхэгээс явж байна гээд энэ том лам нар энэ тэр дайрч гарч байсан тухай дуулсан?

Хайвжунай: За ер нь тийм, хүн хэлдэг юм. Зүгээр би өөрөө мэдэхгүй даа, тэгж байсан л гэдэг юм.

Гантулга: Төвдийн тэр хийдийн дацангаас явж байсан энэ тэр гэсэн тийм юм бол дуулаагүй?

Хайвжунай: Дуулаагүй, би ерөөсөө мэдэхгүй юм, тэрнийг бол. Зүгээр ер нь манайхаас ч гэсэн тэр Гүмбэд очиж нэг хоёр гурван жил болоод ирсэн хүмүүс байсан даа. Тэр миний хэлээд байдаг тэр Ням ловон гэдэг чинь ч очоод л нэг гурван жил болоод ирж л байсан. Өлзийжанцан гэж нэг миний үеийн, арай надаас ахдуу тийм хүн. Тэр бас нэг хоёр гурван жил болоод ирж л байсан. Тэнд очиж Гүмбэд очиж нэг ном үздэг л байсан.

Гантулга: Суварганы хурал бол одоо энэ дацан болгондоо жастай юу?

Хайвжунай: Тийм.

Гантулга: Хоёр, том бага хоёр дуган нь хоёулаа жастай юу?

Хайвжунай: Жастай.

Гантулга: Нийтдээ ер нь тэгээд л нэг хэдий орчим жас байсан бол? Тав зургаа?

Хайвжунай: Үгүй ээ ер нь тэгээд л нэг дөрөв л байсан байх даа.

Гантулга: Тэр жасууд нь нэртэй байсан уу, тийм юмны жас энэ тэр гээд, цогчин дуганы жас цогчин жас ч гэдэг юм уу?

Хайвжунай: Нэртэй байсан. Цогчин жас ч гэж л байна. Мамба жас ч гэж л байна. Тэр хэдэн нэртэй байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Ер нь жас мал , хувь хэртэй байсан, олонтой байсан уу? Хэр баян жас байсан?

Хайвжунай: Намайг байж байхад бол нэлээн цөөхөн жастай байсан. Тэрнээс өмнө бол нэлээн баян жастай, хонь энэ тэр олонтой.Хонийг нь одоо тордож маллах хүн олдож өгөхгүй энэ тэр байсан гэж ярьдаг юм байна л даа.Зүгээр одоо намсайг байж байхад цөөхөн л юм байж байсан.

Гантулга: Энэ одоо Богд, Богдын шавьд ч гэдэг юм уу, хошууноёнд алба өргөдөг байсан уу? Сүмийн жасаас бол?

Хайвжунай: Еэ дээ тэрийг мэдэхгүй юм.Үгүй шахуу л байгаа даа , ер нь бол.

Гантулга: Энэ лам хуваргууд нь Цагаан сүварганыхаа сүмийн эргэн тойронд нь байшин саванд байж байсан уу, эсвэл гэрт сууж байсан уу? Жаахан зайта байсан уу, нэг дороо байсан уу?

Хайвжунай: Нэг дороо байсан.Зарим нь байшинд байсан, голцуу гэрт байсан.Хашаанд гэртэй.

Гантулга: Тэгээд л гэрт?

Хайвжуна: Тийм.

Гантулга: Одоо том хурал шиг тийм юмны аймаг гэж бол хуваагдсан юм байхгүй юу?

Хайвжунай: Үгүй, байхгүй.

Гантулга: Цагаан сүварганыхаа одоо үндсэн харъяалалд байпаг болоод, харъяалалд байдаггүй лам нар, тийм хандмаа нар энэ тэр гэж байсан уу?

Хайвжунай: Үгүй , байхгүй.

Гантулга: Цож лүйжин тавьдаг тийм лам нар байх уу?

Хайвжунай: За ер нь байхгүй шүү.Энэ тэндээс хүн хүрч ирж л цож лүйжин тавьдаг. Урьдаг байсан юм уу, зүгээр ирдэг юм уу тэгж нэг хааяа л ганц хоёр юм үзэгддэг. Тэрнээс биш энд тийм юм байхгүй.

Гантулга: Одоо нөгөө лам хуварга улсууд бол өдөр тутмынхаа амьдралыг яривал, одоо өглөө эрт босчихоод одоо юу хийх вэ? Орой болтол одоо ингээд номоо шүүлгээд л хурлаа хураад л , ламынхаа одоо өглөө босоод орой үдэш унтах хүртлээ хийдэг юмыг товч яривал, лам хүнийхээ хувьд?

Хайвжунай: Үгүй би одоо нэг бага хүүхэд юм.Би өөрийнхөө тухай ярьа.Өглөө, би чхатуу, тэр манай багш их хатуу захиргаатай тийм хүн байсан л даа.Тэр Ёндон үнзад гэж.Өглөө за ер нь одоогийнхоор бол таван цагт босно.Тэгээд зуун найм мөргөнө.

Гантулга: Бурханд?

Хайвжунай:Бурханд, тэгээд мөргөчихөөд тэгээд номоо нэг давтана.

Гантулга: Уншлагануудаа?

Хайвжунай: Тийм.За тэгээд, хүнтэй ярих...тэрнээс өмнө хүнтэй ярихгүй.Хүнтэй ярих хоол унд идэх тийм эрхтэй болно.Хоол унд ч идэхгүй, хүнтэй ярихгүй ухаан муудна.Тэгээд л нар гараад л , тэгээд л цай уучихаад л хичээлээ давтаад л тэгээд л байж байтал нар гарна.Нар ханын толгой руу орох алдад тэгээд шүүлгэнэ.Одоо өчигдрийнхөө хичээлийг номыг одоо шүүлгээд л ...

Гантулга: Цээжилсэн номоо?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хайвжунай: Тийм.Тэгээд л тэрнийгээ одоо алдаагүй сайхан шүүлгэчихвэл тэгээд л дараагийхийгаа хэмжүүлж аваад л тэгээд л ...Тэгээд л бид гурвуулаа орныхоо өмнө нэг нэг олбогтой, олбогныхоо өмнө нэг нэг ширээтэй.Ширээн дээрээ л номоо тавьчихаад тэгээд нөгөө...

Гантулга: Тэмдэглэж авсан номоо?

Хайвжунай: Зааж авсан номоо л үзнэ.Тэгээд л яг цагтаа шүүлгэнэ, яг тэр шүүлгэж аваад л тэгээд л одоо гадагшаа жаграй гэж ярина, гортиг.Гортиг гээд нэг хөндий юм байсан.Тэр цагтай, үгүй ер нь яг цаг харах юм байхгүй, гэхдээ тэр нараар юугаар...

Гантулга: Баримжаагаар?

Хайвжунай: Тийм.Тэгээд л тэгж ирчихээд л тэгээд л номоо үзэж тэгж байж байгаад л тэгээд л үдийн цайнд орно доо.Тэгээд л үдийн цайнд орчихоод л , хийх ажил байхгүй л дээ, бидэнд.Тэр ойрхон нэг хоёр зуун метрээс үс авна. Тэрнээс өөр гадуур, бид хоёрыг бол гадуур гаргахгүй.Гадуур хүүхдүүд ноцолдоод л , тэгээд л шуугиад л тэгж л байна.Бидэнд тэрүүнд очих эрх байхгүй .Ерөөсөө гаргахгүй.Тэгээд л нэг бие засах хугацаатай, Тэрүүндээ л гарч бие засна.Тэгээд л оройхон хичээлээ яаж байгаад л тэгээд орой хоолоо идчихээд л бас нэг жаахан сууж байгаад л тэгээд л унтана.Бүр шөнө оройхон унтана аа.За тэр манай багш тэгэхэд чинь одоо ном л уншаад байна.

Гантулга: Өөр юм бодолгүй?

Хайвжунай: Өөр юм бодолгүй ном уншаад л, ном уншаад байна.За тэгээд шавь нар нь , гадуур суудаг шавь нар нь нэг ном уншиж номоо шүүлгэж хэмжүүлж аваад явна.Тэгээд явна, тэрнийг нэг хэлж өгнө.За тэгээд хуралгүй цагт бол тэгж л байна. За тэгээд хуралтай цагт бол яахав дээ, тэгээд л цугаараа хоол ундаа...

Гантулга: Өглөөний хурал хэдийд эхэлдэг байсан юм бэ?

Хайвжунай: Үгүй ээ ер нь тэгээд л одоогоор бол өмн л нэг ес, арван цагт л эхэлдэг байсан байх юм.

Гантулга: Тэгээд л хуралдаа?

Хайвжунай: Тэгээд л хуралдаа тэр чинь одоо яахав дээ тэгээд л хуралдаад л .Зарим хурал бол цавтай байх юм.Тэгээд л манж цав хуралдаа яаж байгаад л тэгээд л орой л тарна л даа, ер нь.

Гантулга: Хэдэн цагийн үед тарах уу?

Хайвжунай: Үгүй мөн л нэг тав зургаан цагийн алдад л тардаг байсан шиг байгаа юм.

Гантулга: Одоо та бол залуу лам байсан болохоор, хүнд ном унших , гүрэм дором хийж өгөх гэсэн юм бол байхгүй юу?

Хайвжунай: Байхгүй ээ, би тэгэхэд чинь юун тэгэх.

Гантулга: Том багшү чинь, үнзад багш чинь болвол?

Хайвжунай: Хийнэ ээ, явна.Улсуудад залагдаад л явна.

Гантулга: Овоо тахих?

Хайвжунай: Овоо тахина.

Гантулга: Бас залагдаад л явах уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хайвжунай: Залагдаад л явна.

Гантулга: Аль хэр жисаа даллага авах бол?

Хайвжунай. Тийм юм одоо цогчин жас л юм зохион байгуулж тахидаг байсан.

Гантулга: Тэр байж байсан байр хашаа хорооноос бол өөр ойр айл, хар улсууд байсан уу, байхгүй юу?

Хайвжунай: Бараг үгүй шүү.

Гантулга: Цуг дороо сууна гэж байхгүй юу?

Хайвжнай: Ер нь байхгүй. Дандаа лам нарынх л.

Гантулга: Одоо урч, гар урчууд гэдэг юм уу, жасын гэхэд чинь л тэр жасын мал маллаач гэдэг юм уу, тэр улсууд нь?

Хайвжунай: Энд байхгүй ээ.

Гантулга: Ерөөсөө тийм юм байхгүй юу?

Хайвжунай: Ер нь ...тэр нэг жаал юм хийдэг, тийм нэг ганц хүн, ганц айл байсан юм. Тэр нь нэлээн хол...

Гантулга: Захдуу?

Хайвжунай: Тэр урд толгод дотор байдаг байсан юм.

Гантулга: Тэр нь бол яадаг хүн байсан юм бол?

Хайвжунай: Аан ?

Гантулга: Тэр хүн нь бол юу хийдэг хүн байсан юм бол?

Хайвжунай: Аа одоо тэгээд л нөгөө тогоо , тийм домбо, данх тийм юм нөхөх барих тийм л юм хийж байсан.

Гантулга: Түлээчин энэ тэр бол байгаагүй юу, түсгай түлээчин үсчин?

Хайвжунай: Үгүй ээ нэг энэ Хонгорын голд нутагтай Даваа гэж нэг өвгөн байсан юм. Тэр л одоо түлээг нь түүчихнэ, усыг нь авчихна, манжийг нь чаначихна, тийм л хүн байсан юм.

Гантулга: Энэ ойр хавийнх нь бол эргэж мөргөхөөр бол өдөртөө эргэж мөргөчихөөд л явчих уу, нэлээн удаан бас эмнүүлж бариулж байдаг юм уу тэгэх үү?

Хайвжунай: Үгүй, энэ өдөртөө мөргөөд л явна. Эргэлтэй өдөр бол хонохгүй л дээ, тэгээд л ...

Гантулга: Эргэлчин мөргөлчин гэж байран суурин байхгүй юу?

Хайвжунай: Байхгүй.

Гантулга: Сүм хийд, энэ Цагаан суварганы ойролцоо наймаа, худалдаа зээл мээлийн газар?

Хайвжунай: Байхгүй, юу ч байхгүй. Тэр бол юу ч байхгүй.

Гантулга: Арилжаа , хятад наймаа?

Хайвжунай: Байхгүй ээ байхгүй. Юу ч байхгүй.

Гантулга: Явуулын наймаа ч байхгүй юу?

Хайвжунай: Байхгүй.

Гантулга: Одоо энэ сүм хийд хаагдлаа ш дээ, гучин долоон онд?

Хайвжунай: За.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэгэхэд та одоо энэ хуралдаа суухаа больсон уу, хэзээ одоо энэ хурлаа орхисон бэ?

Хайвжунай: Үгүй ээ тэр чинь одоо, 1932 он билүү 1933 он.

Гантулга: Гучин долоон онд гэж яриад байгаа юм?

Хайвжунай: Үгүй ээ манай энд гучин гурван онд л тэр сахиус нь... Дамдин Чойжоо, тэгээд нэг жижиг номыг нь л нэг хэдэн өдөр уншаад, арван хэдэн өдөр л уншсан байх. Тэгээд л тэр хойноос Новоохамба гэж багш ирээд л хүрээнээс ирдэг. Тэр хүн л одоо явж байгаад л өө та нар тэр сахиусаа тэгж байгаад л хаачих гэсэн л юм гэнэ лээ. Тэгээд л тэр сахиус, манайхан тэр баруухан араар ойрхон бүүчихсан юм, өнтй ч ижл байсан. Тэгээд л унага уячихсан, тэгээд л өдөрт айраг авчраад л дуганы голд тавьчихна. Тэгээд л лам нар чинь айраг уугаад л, тэр юугаа сахиусаа тахиад л уншаад... тэгээд л нэг арваад хоног тэгж байгаад, сахиус дуусч нэг тоонд хүрсэн байх. Тэгэд л тарсан даа. Тэгээд л ер нь тэгээд...

Гантулга: Гучин хоёр, гурван оны үед л ?

Хайвжунай: Тийм, гурван оны үед л ... гурван онд л хаасан.

Гантулга: Тэр сүм хийдийг хаа гэж цаанаас нь...?

Хайвжунай: Өө тэр чинь урдаар хүрж ирээд л, яг тэгээд хүрч ирж бас нэг тооллого мооллого хийсэн үү, яасан. Тэгээд дахиж орж бологүй гээд, үүдэн дээр нь цоожлоозд, үүдэн дээр нь юм бичиж наагаад, лацдаад тэгээд тэр чинь аваад явчихсан.

Гантулга: Энэ хошуу тамгын газраас ирсэн үү тийм ээ?

Хайвжунай: Үгүй ээ тэр чинь тэгээд аймаг болчихсон байсан байх даа.

Гантулга: Аймагаас ирээд л ?

Хайвжунай: Тийм, аймагаас ирээд л, тэгээд л...

Гантулга: Тийм хүн байсан гэж нэр усаар нь хэлэх, тийм албан тушаалын гэж?

Хайвжунай: Алга аа, чадахгүй юм.

Гантулга: Сүм хийд хаагдсаны дараа тэр дороо лам нарыг бариад тавьчихсан уу, эсвэл сүүлд нь ?

Хайвжунай: Өө тэр нэлээн дээхэн, тэрнээс чинь ноднин үржнэнгаас нь эхлээд л, барьж аваад л явдаг, барьж аваад л явдаг, тэр хурал ном хүрж байхад чинь ч гэсэн аваад л явдаг, тэгдэг л байсан. Тэр чинь нэлээн өмнө эхэлсэн.

Гантулга: Тэгээд баригдах нь баригдаад л, баригдаагүй нь хар болоод л явсан үү?

Хайвжунай: Ерөөсөө хар болоод л, хар болгох... Тэгэхгүй бол тэр чинь нөгөө ламын татвар гээд жигтэйхэн юм төлнө. Тэрнийгээ төлж чадахгүй, тэгвэл тэгээд л бушуу л хар болохыг боддог байсан л даа. Тэгээд л хар болох дээр чинь зэрэг бүүтай, хутгатай нэг хүүхээнтэй болвол л тэгээд хар болж байгаа болохлээр... Бас тэгээд нэг жинхэнэ хар болж байна гэж үзэхгүй.

Гантулга: Заавал хүнтэй сууж?

Хайвжунай: Тийм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Одоо тэр баригдаж тавигдаад явсан улсад нь юу тохиолдсон талаар бол тухайн үед чимээ сураг гарч л байсан байх даа?

Хайвжунай: Гарч л байсан даа.

Гантулга: Жишээлж ярихад, танай хурлын лам нар, тэр ламыг тийшээ авч яваад тэгчихжээ ч гэдэг юм уу?

Хайвжунай: Өө тэгээд л барьж аваачаад л одоо аймаг дээр нэг гэрт аваачаад л хийдэг юм байна. Тэгээд л гаднаас нь , тэр гэр ч одоо дэвсгэр мэвсгэр тийм юм байхгүй байна. Нэг шороон дээр, тэгээд л өнөө яаж үзээгүй юм нь ядарч туйлддаг юм байна, зарим нь ч одоо тэгээд... Ер нь тэр ядаргаанаасаа ч тэгээд зарим нь үхэж байгаа сураг дуулдана. Тэр манай багш бол машинаар очсон. Өнөө машинаар явж үзээгүй улс чинь баахан бөөлжиж, цайлжаад л очдог юм байна. Тэгээд л тэрүүгээр чинь очоод л ер нь л муухан шуу л дуулдаг байсан. Маргааш нь гайгүй болдог юм байна. Тэгээд л нэг хэд хоноод л хоолтой ундтай, хоолгүй шахуу. Тэгээд л ер нь бараг нэг шөнө ачаад явсан л гэдэг юм.

Гантулга: Тэгээд л сураг тасарсан?

Хайвжунай: Тэгээд л сураг тасарсан.

Гантулга: Энэ хийд хаагдахад дараа нь энэ гучин хоёр, гурван оны үед нөхцөл ингээд л хаалттай лацтай чигээрээ л байж байсан уу?

Хайвжунай: Үгүй ээ тэгж байгаад л нэг хэдэн жил ч болсон, нэг хоёр жил шахуу болсон байх аа. Тэгээд л хүрч ирээд л энийг чинь, бас нэг хэдэн улсууд, нэг баруунтаа нэг юу байсан, нэг бааюу.

Гантулга: Тоосго шатаадаг?

Хайвжунай: Тоосго шатаадаг. Тэрүүнд л номыг нь хийгээд шатаагаад л байдаг, шатаагаад л байдаг. Тэгээд л ингээд л шатааж барагдаагүй, өө нэг жигтэйхэн юм. Ингээд л нэг энэ газраар дүүрэн цаас.

Гантулга: Тэгээд л ер нь бол сүйтгээд хаячихсан?

Хайвжунай: Сүйтгээд хаячихсан.

Гантулга: Тэр дуган муган нь тэр сүүлд хэдий үе болтол?

Хайвжунай: Үгүй тэгээд тэрнээс хойш харин тэр дуганыг чинь аваад , энд нэг артел байгуулаад л давс чанаад... Энэ давс чинь ийшээ манай энд давс гайгүй л дээ. Эндэс чинь энэ нэг жаран км юм уу даа. Тэндээс давс ачаад, авчраад тэмээгээр л авчирна. Тэгээд тэр дуган дээр чинь хэдэн том давс чанадаг тогоог байгуулаад, тэгээд нэг хээдн жил давс чанасан.

Гантулга: Дараа нь?

Хайвжунай: Үгүй тэгж байгаад л нэг ноос авсан. Тэгээд л намайг цэрэгт явсан хойгуур нураачихсан, алга болчихсон байсан.

Гантулга: Тэгээд тийм ийм юманд хэрэглэсэн энэ тэр гэж дуулаагүй юу та?

Хайвжунай: Дуганыг уу?

Гантулга: Тийм, сүмын байшин, захиргааны байшин ч гэдэг юм уу, сургуульд хэрэглэсэн энэ тэр гэж?

Хайвжунай: Үгүй үгүй, харин тэгээд нураачихсан юм гэнэ лээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Ерөөсөө нураагаад л хаячихсан?

Хайвжунай: Ерөөсөө нураагаад л хаячихсан.

Гантулга: Энэ бурхан тахил, ном судар, шүтээнээс ийш тийшээ авч, үлдэж нууж барьсан юм дуулаагүй юу?

Хайвжунай: Байхгүй шүү, бараг байхгүй. Бараг үрэгдсэн.

Гантулга: Тэгээд л тэр чигтээ үрэгдсэн?

Хайвжунай: Тэр чигтээ үрэгдсэн.

Гантулга: За за ингээд нэг хоёр асуулт асуучихаад ярилцлагаа дуусгая. Энэ хурал хаагдсаны дараа та ямар ажил эрхэлж байсан бэ?

Хайвжунай: Хурал хаагдахлээр зэрэг би тэгээд л хөдөө гараад л, тэгээд л мал малласан, адуу малласан.

Гантулга: Гэр бүлтэй болсон үү?

Хайвжунай: Үгүй ээ, болоогүй. Тэр чинь хүүхэд байсан юм чинь.

Гантулга: Тэгээд л нас бие гүйцээд?

Хайвжунай: Тэгээд л яахав дээ, би чинь хорин настай цэрэгт явсан. Тэр хүртэл чинь би, тэгэхэд би шинэ үсэг, хуучин үсэг аль алийг нь сурсан. Тэгээд л нэг багийн хуулагч, тэргүүлэгч...

Гантулга: Тийм ажил хийсэн?

Хайвжунай: Тийм ажлыг хийсэн. Багийн айл хэсэж, тэр бол яахав дээ, ухаандаа одоотаниулах, байлдаан ийм байна шүү/ инээв/

Гантулга: Тэгээд л тэтгэвэртээ гараад л ?

Хайвжунай: Тэгээд л цэрэгт явсан. Цэрэгт таван жил болсон. Тэгээд л дөчин таван хоног байлдаанд гараад л, тэнд явж байгаад. Тэгээд би чинь ахмад дайчин ухаантай юм.

Гантулга: Тэгээд ирээд буцаад малаа малласан үү?

Хайвжунай: Тэгээд л ирээд л, жинд их явдаг байсан. Нэлээн тэмээтэй айл байсан. Жинд явна. Цэрэгт явахаас өмнө ч нэг хоёр гурван жил жинд явсан.

Гантулга: Хаашаа жинд явах үү?

Хайвжунай: Өө дандаа Улаанбаатар, тэгээд л би дамжаад л Цагаан айраг нэг л явсан, жингээр. Тэгээд Улаанбаатар тав арван удаа.

Гантулга: Өөр ямар ажил хийж байсан та?

Хайвжунай: Үгүй тэгээд л цэрэг явж ирчихээд л нэг жил жинд явчихаад л, нэг жил нэг хөдөө ажиллачихаад л тэгээд л эвлэлийн хүрээн дарга хийсэн. Тэгээд л сумандаа эвлэлийн хүрээн дарга хийж байгаад л, үрд жил Ноёнд очиж нэг жил эвлэлийн хүрээн дарга хийж байгаад л тэндээ сумын орлогч болоод л. Тэгээд л сумын орлогч нэг хоёр жил хийгээд л, тэгээд л нэгдлийн дарга болсон. Нэгдлийн дарга нэг арван хэдэн жил хийсэн, нэгдэл сум нэгдлийн дарга гэж. Тэгээд л нэг намын үүрийн дарга нэг арван хэдэн жил хийсэн. Тэгээд л хамгийн сүүлд нэг тэтгэвэрт гарахаасаа өмнө ардын хянан шалгах хорооны дарга найм есөн жил хийв үү дэ, бараг арваад жил хийсэн. Тэгээд л тэтгэвэрт гарсан. Үгүй тэтгэвэрт гараад одоо нэг хориод жил болж байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэтгэвэрт суугаад уу?

Хайвжунай: Тийм.

Өмнөговь аймгийн Сэврэй сумын Цагаан суварганы хурал, Жасрай гэгээний тухай

Гантулга: Жасрай гэгээний тухай ярилцлага авах гэж байна.

Хайвжунай : За манай хошуу Жасрай гэгээн гэж ганц гэгээнтэй байсан юм билээ. Тэгээд энэ их сүүлд бий болсон юм гэнэ лээ. Тэгээд тэр Жасрай гэгээн хаанаас яаж гарч ирсэн юм бэ гэхлээр хүний одоо дамжиж ярьсныг л хэлэхэд далай лам Даянжамц далай лам төвдөд одоо тодорч суугаад тэгээд одоо эхнэр аваад эхнэр жирэмсэн болоод ингэж байж байхад нв төвд, тангадууд ер нь жаахан хүн муутай улс юм байна. Энэ лам хүн ингэж байна гээд матаад, эзэн хаанд матдаг юм байна. Тэгээд эзэн хаан шалгалт явуулаад үзсэн чинь үнэхээр хүүхэн аваад, хүүхэн нь жирэмсэн байсан. Тэгээд шалгалт ирээд үнэхээр тийм байна гээд. Тэгээд эзэн хаан зарлиг гаргаад хоёуланг нь цаазаар ав гээд зарлиг гаргачихдаг юм байна. Тэгээд хүн явуулаад ингээд хүүхнийг нь олоод гэдсийг нь хагалаад үзсэн чинь Хоролжирвээ хаан ингээд сууж байдаг юм байна.Тэгээд нөгөө очсон улсууд нь ингэлээ, ингэлээ эзэн хаанд бас мэдээ барьдаг юм байна.Үгүй одоо яахав, нэгэнт хааны зарлиг бол зарлиг л байх хэрэгтэй гээд хоёуланг нь ал ал гэж ингээд бүцаад явуулдаг юм байна.Тэгээд л өнөөхийг чинь алахаар хоёр ч юм уу, гурван ч юм уу хүн ирдэг.Тэгээд л алах гээд л , өнөө алдаг газар тусгай байдаг юм байна. Өнөөх рүүгээ явдаг. Харж чаддаггүй өнөө хоёр чинь.Тэгээд л цаашаа яваад байдаг. Тэгээд өнөөхийг чинь би чамайг алж чадахгүй нь, чи одоо яв гээд нэгэнт хааны зарлиг юм та нар ал ал гээд өнөө хүн чинь тэгээд байдаг. Тэгээд алж чаддаггүй.Тэгээд яваад байж, хэдэн өдөр ч явдаг юм яваад л байтал харин нэг үхсэн хүн тааралдаж.Тэгээд нөгөө хоёр чинь чи энийг өөрийгөө болго тэгээд энийг аваачиж өгье гээд өнөө далай ламыг тэгсэн. Өнөөх чинь толгой дээр нэг чулуун дээр сандайлчихаад л шүдээ чигчлээд л , нүүр лүү нь нулимаад л ингээд л сууж байсан. Тэгээд л чи одоо яв яв гээд тэгээд л яваад өгсөн юм гэнэ лээ. Тэгээд л наадах чинь одоо ингээд ингээд алчихлаа гээд өнөө хүн тэгээд...Тэгээд шинжээч явуулдаг юм байна. Тэгээд шинжээч явуулаад үзсэн чинь үгүй ээ, өвөр тал нь мөн байх юм. Ар тал нь биш байх юм, үгүй ээ тийм юм гэж яаж байх вэ. Мөн л юм байлгүй, тэгээд мөн гэсэн шийдвэр гаргаад. Тэгээд л нөгөө хүүрийг нь үзүүлээд л , тэр хүүрийг яадаг юм, устгадаг шатаадаг л юм байгаа биз дээ. Тэгээд л наад тэр Даянжамц далай лам хойшоо яваад л , энэ Орос энэ тэр хойд талын энэ Буриад муриадаар ингэж явсаар байгаад. Тэгээд л хойд дүр нь юм байлгүй дээ, чимээ тасарсан. Тэгээд л одоо энэ Өвөрмонголын Рашаан хошууны, энэ баруун хошуунд нэг арваад настай хүүхэд. Хаанаас гарсан нь мэдэхгүй. Айл хэсээд л ингэж амьдардаг хүүхэд байж. Тэгээд нэг баян айлд хонийг нь хариулдаг. Хонийг нь хариулаад л явж байсан нэг хонь нь чононд идүүлчихэж. Тэгэхлээр нь тэр баян айлын эзэн ашилж, загнаж чи одоо хонь төлж өг гэж. Тэгээд л гараад явчихсан. Гаднаас нөгөө хонийг дуудсан. Тэгээд гараад харсан чинь чоно ногтолчихсон бариад энэ чинь л идсэн шүү дээ гээд. Тэгээд л чи одоо наадхаа тавь гээд, нэг жаахан хөлс өгдөг юм уу яадаг юм. Чи одоо манайхаас яв гээд ингээд явуулчихдаг юм байна.Тэгээд л явж байгаад нэг хэдэн

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ямаатай хөгшнийд очиж зарагдаад хэдэн ямааг нь хариулдаг. Өдөрт нэг жингийн ваараар тараг бүрж өгдөг, өдөр ямаагаа хариулаад ирэхлээр нь.Тэгээд сүрчихсан. Нэг өдөр тэгсэн таргаа долоогоод л , өнөө ваараа долоогоод л жигтэйхэн байна гэнэ.Үгүй чи нэртэйгээр нь эргүүлээд долоочих л доо гээд л хөгшин тэгж , тэгсэн эргүүлээд долоочихож. Ээ чи надад зарагдаж байхаар хүн биш байна. Чи яв гээд л , жаахан хөлс өгөөд л явуулж. Тэгээд бас нэг тийм банди байдаг юм аа, одоо мартчихаж. Тийм нэг хүүхэд, тэгээд л Жасрай гэгээнээр баруун хошуунд өргөмжлөөд л .Тэгээд тэнд байж байгаад тэр нь нас бараад, дахиад нэг Жасрай гэгээн тэндээсээ сонгоод байж байгаад тэгээд өнөөдөх нь бас нас барах. Тэр Жасрай гэгээний баруун том ламтай манай эндхийн Аяа зурхайч гэдэг хүн жигтэйхэн танил.Тэгээд тэр танил тэр Жасрай гэгээнийг нас барахаар нь , тэр Рашаан баруун хошууны ноён өөрийнхөө хүүг өргөмжилчихдөг юм байна.Тэгэхээр нь тэр баруун лам нь наашаа ирж Аяа зурхайчтай уулзаад ингээд ингээд яачихсан. Тэгээд намайг энүүгээр олж авах хүн байвал олж ав гээд нэг эрх, нэг хөөрөг юу юу байдаг билээ дээ, нэг аяга билүү.Нэг гурван юм ингэж өгсөн. Чи энийг аваад яв. Би ер нь баруун урагшаа төрнө гэж, Хятадад төрнө гэж ингэж хэлсэн юм чинь гэж хэлдэг юм байна. Тэгээд л хэл дуулгачихаад явж. Тэгээд Аяа зурхайч энд наад ноён моён тэр улсуудтайгаа уулзаж байгаад өөрөө мэргэлээд үзсэн, сайн мэддэг хүн байсан юм байна. Тэр урд талын Согоо хотод төрсөн буудаг юм байна аа.Тэгээд л бэлтгэж аваад л өнөө хүн дээрээ очоод л өнөө баринтагийг нь аваад л , тэгээд л цаашаа хэдүүлээ тэр Согоо хот руу яваад л . Согоо хотод эрээд байдаг,олддоггүй ээ.Тэгээд л яахав дээ, нэг тэмээ уначихаад л нэг айлд орчихоод л . Тэр баруун хойд захад олон хүүхэдтэй ядуу айл байдаг юм. Тэр жилд нэг хүүхэд гаргасан юм, хоёр гурав хоног гэгээрсэн гэж нэг тийм юм сонсоод. Тэгээд л тэр баруун хойд талаар нь явж байтал нэг цав цагаан байшингийн орой дээр хэдэн хүүхэд тоглож байна. Гэнэтхэн харин нэг монгол хэлээр ах аа, та тэр миний эрх өгөөдөх гэдэг юм байна. Тэгээд л буугаад л тэр айлтай танилцаад л ,маргааш нь бас хүрч ирээд л .Өө нэг хүүхдүүд нь өдөрт нэг мантуу идэж цай уудаг. Тэгэхлээр тэр хүүхэд орж ирээд л жиндий ламса чол, жиндий ламса чол гээд л өнөө хэдэн аягатай мантуундаа адис өгөөд л. Энэ нэг учир боллоо гээд л .Тэгээд л маргааш нь дахиад явж байсан чинь хүүхдүүд чулуугаар тоглоод л чамайг чүнжигнооров гэж хэн мэдэхэв ээ, намайг Шаянжамц далай лам гэж хэн мэдэхэв ээ гээд тоглож байх юм. За тэгээд л бүр одоо тодорхой боллоо.Тэгээд л маргааш нь ирээд л за танайх нэг хүүхэд үрчлүүлээд өгөөч, өргүүлээд гээд л тэгсэн тэг манайх чинь олон хүүхэдтэй, тэг ав гээд л дуртай зөвшөөрч байна, Хятад айл. Тэгээд л маргааш нь хүрч ирээд л аль хүүхдээ ямар хүүхдээ өгөх вэ гээд л , үгүй ээ өөрөө үзэж , өөрөө л ав алийг нь ч авч болно. Тэгэхлээр нь өнөө хүүхдээ зааж, үгүй ээ энэ хүүхдийг чинь авбал яадаг юм бэ? Үгүй ээ тэг тэг, энэ чинь ад бүрийн ааштай хүүхэд байгаа юм. Энийгээ ав , энийг ав гээд л. Тэгээд л тэр хүүхдийг авахаар хэлэлцээр хийгээд л , тэр ноёд моёд бүх хүмсүүстээ хэлчихээд л . Тэгээд л нэг том лам, тэр ноёд энэ тэртэйгээ аваад л нэг гурван настай, за дөрвөн настай юм уудаа. Тэгээд л таван настайд нь энэ Байшинтын хийд дээр тэр Жасрай гэгээнийг өргөмжлөөд л , тэгээд л манайх тэр Жасрай гэгээнтэй болсон гэж байгаа юм.Тэгээд л тэр нас бараад л тэгээд л энэ зүүнтээ Тэширийн энд оршуулаад л , тэнд шатаагаад чандарласан юм гэнэ лээ. Буурал гэгээн ч гэдэг юм, нэрийг нь мэдэхгүй.Хятад хүн. Тэгээд хойд дүрийг нь их л ажил болдог байж л дээ, далай лам Ванчин богдтой уулздаг. Тэгээд л тэр насны

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хүүхдүүдийг дахин дахин шалгаад л , хассаар байгаад сүүлд нь нэг хоёр хүн үлддэг юм уу. Тэгээд л тэрэн дотроос шалгуур авдаг байна.Тэгээд л тэрүүн дотроосоо, манай эндээс хоёр ч хүн гэгээн болох гээд л , нэг нь жаахан сагсуу хүн байсан юм. Гэгээн гэж өөрийгөө тэгдэг байсан л даа.

Гантулга: Гэгээн юу гэнэ ээ?

Хайвжунай: Гэгээн. Өөрийгөө гэгээн болгох гээд, тэр нэг тэрүүнд нэг шалгарсан байхгүй юу, настай. Тэр нохой жилтэй хүн, одоо байж байгаа байх аа, тэр нохой жилтэй гэдэг чинь нэг 84 настай л хүн байгаа байх.

Гантулга: Нөгөө хүн нь ямар хүн байсан юм?

Хайвжунай: Үгүй ээ, харин би тэрийг л ярьж байна л даа.Тэгээд л тэр хүнийг урдаас шалгаад л , нуур байдаг юм гэнэ лээ.Нуурын хажууд нэг 3 хоног нямба хийдэг юм гэнэ лээ. Тэгэхээр тэр усан дотроос яг тэр хүний дүрээрээ үзэгддэг юм гэнэ лээ. Тэгээд л баталж авдаг.Тэгээд л тэр Жаал гэгээн Дашням гэдгийг энэ, ноён Дэнжингийн Дашням гэж. Тэрнийг болгоод, багшаар нь Аграмба багшийг тавиад. Тэгээд л энд байж байгаад, тэгээд энэ төр эргээд тэгээд л барьсан юм гэнэ лээ, тэр Жаал гэгээнийг.Тэгсэн өнөөх чинь жаал муу хүүхэд, нэг чихрийн цаас түүгээд л . Конторт оруулаад байцаах гэсэн чинь чихрийн цаас түүгээд ер болдоггүй, тэгээд одоо ямар юм ,бариад яахав гээд тэгээд тавьчихсан юм гэнэ лээ. Тэгж байтал бас хойшоо нэг баригдаад нэг хот ороод, тэгээд тэндээсээ цэрэгт яваад.Тэгээд цэрэгт байж байгаад нэг жил болсон юм уу даа, тэгээд жанжны шалгалт гэж ирдэг шүү дээ, жилд нэг.Тэгээд жанжны шалгалтаар маршал тэнд явж, тэгээд жанжны шалгалтын нэг сүрхий юм нь бууны шалгалт шүү дээ, буугийг нь арчиж цэвэрлэдэг. Тэгээд буугий нь үзсэн чинь тэр олон буун дотор нэг жигтэйхэн сайхан арччихсан бүү байна. Энэний эзэн хаана байна, тэгтэл тэр Жасрай гэгээн би гээд л , хүрээд ир.Чи энэ бүүг яаж арчихлээрээ ийм байдаг юм, үгүй ээ эргүүлээд л арччихсан юм. Тэгэхээр өнөөдөх чинь тоглоом хийлээ гэж боддог юм уу даа, чи тэгвэл одоо эргүүлээдэх гээд л .Тэгсэн нээрээ өнөөхийг чинь эргүүлээд. Энийг халчих, халаад явуулчих гээд л .Тэгээд л дор нь шийдвэр гаргаад л халаад л , тэгээд л энд ирсэн юм гэнэ лээ. Тэгээд л энд нэг архи уусан, авгай хүүхэн эргүүлсэн хүн давхиад л тэгж байж байгаад 28, 29-тэй байна уу даа хатгалаг тусаад. Тэгээд энэ зүүнтээ нэг айлын хүргэншүү болж байгаад.Тэр айл нь ч хүүгээ шоолоод тэгж байгаад л нас барсан юм.Тэгээд л тэрнийг мөн тэр Тэширийн хонхорт аваачаад чандарлачихсан юм. Тэгээд л тэр нь манай энд өндөр өвгөн гэж бас юм мэддэг л өвгөн байсан юм. Тэр тэгж л байсан л даа, нас барахад нь тэрнийг бол би мэдэж байна. Ээ хөөрхий гэгээн энэ ханаар л хүрэн солонго татуулаад л энэ Өвөрмонгол руу явчихлаа гээд тэгж байсан юм. Тэгээд л 2 жилийн дараа өө хөөрхий гэгээн энэ Эзний голд төрлөө шүү дээ гээд л тэгээд л тэгж байгаад өнөө өвгөн ч нас барсан. Тэгээд л чимээ тасарсан . Тэгээд л тэгж байтал нэг хааяа хааяа бөөн юм болж байж гардаг байлаа. Тэгэхэд л тийм гэгээн байна аа, байхгүй байна аа, байна аа гээд л дандаа худлаа хэлж байдаг. Тэгээд л ерэн онд сайхан хил нээгдэхэд би гарсан. Тэгээд л тэр Рашаан баруун хошуунд хөдөө гэртэй , ламын ус гэж нэг газар тэгээд тэнд очоод 4 хоносон тэнд би.Тэгээд л шалгасан.Тэр ах дүү элдэв юм, уул ус мэдэхгүй юмгүй, чухам надаас илүү мэдэж байсан. Тэгээд л мөн юм байна даа гээд л ингээд л тэгээд л мөргөчихөөд л , хойшоо манайд очоорой гэж хэлчихээд...

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэр найман гэгээнийг анх тодруулсан тухайд нь, тэр Жасрай гэгээний сүүлийн дүрийг, ар Халхын найман гэгээнийг?

Хайвжунай: Аа энийг чинь харин ер нь манай энэ Халхаас тэр Рашаан баруун хошууны Алтантэгш гэдэг хийд дээр найман гэгээн цуглах түүхтэй юм аа гэдэг байсан юм. Тэгээд тэндээс тэр найман гэгээн цуглаж байгаад Жасрай гэгээнийг тодруулсан юм. Тэрнээс өмнө бас яах вэ, тэр гурван настайд нь наана Эзний хошуунд Эзний голын Торгуудын ноён бас тодруулаад, гурван настайд нь тэр монголоос улсууд барьсан Дамбадаржаалин гээд хийд байсан юм байна. Тэнд нэг гэр бариад тэгээд тэнд өргөмжилж байсан юм. Тэгээд манай тэр найман гэгээн таван настайд нь наанаас нь шууд авчруулаад тэгээд тэр цаана тодруулаад. Тэгээд тэндээс ахаар нь багш хийгээд, Яндаг гэж их номтой хүн байсан юм гэнэ лээ, ах нь. Тэрүүгээр нь ном заалгаад, тэгээд тэрэн дээр нь таван жил ч гэдэг билүү дээ, тэндээ ном заалгаад. Тэгээд овоо том болохлээр нь зэрэг тэр Гүмбэнд аваачаад гурван жил суулгаад, тэндээс нь аваачаад Лавранд гурван жил суулгаад тэгээд нөгөө Алтантэгшийн хийдийнхээ гэгээн нь болгоод тэгээд тэнд суулгачихсан юм гэнэ лээ. Тэгээд нөгөө улаан хамгаалагчийн үеэр дахиж баригдаад, тэгээд барагийг нь алсан юм гэнэ лээ. Тэгэхдээ хэн гэгээн алагдаагүй, нэлээн тэр цаашаа шоронд ажил хийгээд. Тэгээд надад хийж чадахгүй ажил байхгүй, би бүгдийг нь хийж чадна. Харин би мал алж сураагүй байсан чинь нэг тэмээ алах оногдоод, тэгээд нөгөөдөхийгөө алж чадахгүй яадаг билээ энийг чинь гээд энэ чинь одоо нэг ямааг бол гэдрэг нь харуулаад алж байдаг, одоо энийг чинь яадаг билээ гээд юу ч алж чадахгүй ингээд байж байтал тэнд нэг таньдаг өвгөн байсан. Тэр зааж өгч, тэгээд нэг хүлүүлж байж нугасалж алсан гэж тэгж байсан. Тэгээд тэр хугацаагаа дуусгачихаад за одоо чи юу хийх вэ, лам болвол тэр лам бол тэр лам ажлаа хий, өөрийн чинь дураар болъё гээд тэгээд гаргасан гэнэ лээ. Тэгээд би малчин болно гээд мал маллаад нэгдлийн мал. Тэгээд нөгөөдөх чинь тэр хугацаандаа бас нөгөө нэгдлийн мал чинь хоргоддоггүй, өсч байдаг. Тэгээд нөгөөдөх чинь сайн малчин болсон гэж байгаа. Тэгээд сайн малчин болоод сайн малчны үнэмлэх үзүүлж байна лээ.

Гантулга: Тэгээд ном энэ тэрээ бол мартаагүй, унших уу?

Хайвжунай: Юу, сайхан уншина. Өөрөө бол маарамба эмч хүн. Тэгээд өөрөө харшил энэ тэр болоод чадахгүй юм байвал, хүүгээ маарамба болгочихсон. Одоо хүү нь Өвөрмонголын сайн эмч, тэр эмнэлгийн орлогч дарга нь байна уу. Тэгээд л байж байтал Бээжингээс дуудсан. Үгүй ээ, яах гэдэг юм бол оо гээд л барих тавих юм бодоод. Тэгсэн харин Бээжинд нэг том юу байдаг гэнэ ээ...

Гантулга: Шар сүм гээд, Юүнгээгүний хийд гээд?

Хайвжунай: За, тийм том хийд гээд байдаг.

Гантулга: Тэрний хамба ламаар очсон хүн мөн үү, одоо?

Хайвжунай: Үгүй ээ, тэнд тэгээд суралцсан гэж байгаа. Гурван жил суралцсан. Тэнд гурван жил сургаад, хуучин мэдэх юм чинь тэгээд. Тэгээд л гарахад нь төгссөн үнэмлэх өгөөд, Жасрай гэгээн гэсэн үнэмлэх өгөөд, тэгээд чи тэр нутагтаа очиж дуртай юмаа хий, тэгээд л тэр энэ ажилд ажиллаж байсан. Тэр бол саяхан даа, ерээд оны үед байх.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэр Хөх нуурын Согоо хотын тийшээ анх тэр нэг хятад айлд төрсөн гэхэд нь хэд хоног гэрэл тасраад гэдэг талаар? Нөгөө нэг хүнээс сурч явсан чинь?

Хайвжунай: Аа тэрнийг би хэлсэн. Харин тэр энд Мөнгөндаансран гэдэг айлын үр удам юм гэнэ лээ л дээ, одоо Монгол, манай энэ Нэмэхтийн. Тэгээд тэнд тэр хэн гэдэг билээ дээ, тэр Мөнгөндаансрангийн хэний нэг Иххүүхэн гэдэг билүү, төрөх болж л дээ. Энэ Тостод улаан даацад тэмээ хариулна, эх нь тэмээ хариулдаг байж л дээ.Тэгээд жирэмсэн, үгүй ээ энэ ийм улаан даац гэдэг нэртэй газар төрүүлээд яахав, хэд хоногийн дараа ирж тэнд буулгая гэж ах дүү нар нь Нэмэхтийн өврөөс, Тостын араас цуглаад тэдийд нүүе гэж хэлчихээд ингээд очоод байж байсан чинь өнөө гэр байсан газар нь л гал асчихдаг юм байна. Өнөөх чинь шатчихлаа ингээд гээд маргааш нь нэг ундуу сундуу буучихсан байсан чинь харин төрчихсөн байж байна. Тэгээд энэ ч янзын юм боллоо доо гээд тэгж байж байтал Энэтхэгээс ч байдаг юм уу, Төвдөөс ч байж байдаг юм уу нэг гэгээн явж байж. Ингэлээ ингэлээ гээд асуусан, охин төрсөн гэж байгаа юм. Танай энэ охиноос ичнь их сайн хүн гарах юм байна. Тэрний л тэмдэг байна гэж тэгсэн юм билээ.Тэгээд л тэр охин есөн настай Өвөрмонгол руу гараад л, одоо Жасрай гэгээний эх нь. Есөн настай урагшаа гараад тэгээд тэр өвөрмонголд байж байгаад тэгээд төрсөн хүүхэд гэж байгаа юм. Тэгээд л мөн байгаа юм.

Гантулга: Энэ сүүлийн дүрийг чинь Жасрай ламын нэрийг нь хэн гэдэг вэ?

Хайвжунай: Зүндүйжамц.

Гантулга: Одоо Өвөрмонголд байгаа тийм ээ?

Хайвжунай: Тийм. Одоо миний тулж очиж уулздаг ганц лам тэр.Би жилийнхээ заслыг тэрүүгээр хийдэг юм./инээв/

Гантулга: Тэр Жалсорой гэдэг өвгөнийх нь тухай та жаахан тодруулаач?

Хайвжунай: Огт мэдэхгүй юм.

Гантулга: Тэр Түвдээрээ одоо хааны хөвгүүн гэдэг юм уу, эцэг хөвгүүн гэж орчуулаад байдаг ш дээ. Жал гэдэг нь хааны жал, сорой гэдэг нь хүүгийн хүү. Хааны хүү ч юм уу?

Хайвжунай: Энэ одоо нэрийн л тийм утга байгаа юм.

Гантулга: Тэр найман гэгээн тодуулсан гэсэн. Тэр найман гэгээн нь ямар ямар хутагт байсан бол?

Хайвжунай: За харин тэрийг чинь сайн хэлж мэдэхгүй байна.Дандаа монголын гэгээнүүд л байсан гэсэн. Номч гэгээн гээд л байдаг юм. Одоо хойд пүр нь байж байгаа. За тэгээд Даш гэгээн гэж байгаад саяхан нас барлаа. Зүмбэ шавран гэж одоо байж байгаа. Тэр Даш гэгээн, Номч гэгээн энэ тэр чинь энэ Архангай, Завхан эндхийн л улс юм гэнэ лээ.Тэр Зүмбэ шавран чинь Өвөрхангайн нутгийн хүн байсан юм гэнэ лээ. За тэгээд манай эндхээс энэ Очирдарь гэгээн.Тэгээд тэр Шавруун лам. За тэгээд Жилав хутагт бас байж байсан гэдэг байх. Ламын гэгээн байсан. За байз энэ чинь тэгээд юу болов...Энэ олон гэгээн л тодруулсан. Тэгээд тэр далай лам бол далай лам.

Гантулга: Тэгвэл энэ найм дахь нь Очирдарь гэгээн юм болов уу?

Хайвжунай: Очирдарь гэгээн наана чинь байгаа шүү дээ.Тэгээд тэр цагаан суварга гэж байдгийг бариад, аравнайлуулах ёстой байдаг.Аравнайлах хүн байдаггүй. Үгүй ээ, энийг аравнайлая гээд Шаянжамц далай лам

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

ирж аравнайлах түүхтэй юм билээ гээд ингээд хөдөлдөггүй, тэгээд хэдэн жил болсон юм гэнэ лээ. Тэгж байтал эндээс манай Буурал гэгээн очоод аравнайлчихсан юм гэнэ лээ.Тэгээд л тэр Шаянжамц далай лам нь, тэгээд л ер нь...

Гантулга: Тэр Буурал гэгээн чинь ер нь хурал номдоо суудаг хүн байсан уу?

Хайвжунай: Үгүй, гэхдээ тэр яг Байшинтын хийд дээр. Тэр хурал номонд орж суух юм байхгүй.

Гантулга: Уран хүн байсан гэж байгаа биз?

Хайвжунай: Жигтэйхэн уран. Тэр алт мөнгөөр чинь эмэгтэйчүүдийн юу хийгээд л байдаг.Манай эндээс ч мөнгөний дархан заалгаж байсан хүн, Данзан гээд байж байгаад.Одоо Данзангийн хийц гээд байгаа чинь тэр шүү дээ. Тэр хүний шавь нь.

Гантулга: Аяа зурхайчийн талаар жаахан тодруулаач?

Хайвжунай: Аяа зурхайч чинь одоо манай энэ хойд Баяннуруунд л нутаглаж байсан хүн юм гэнэ лээ, сайн зурхайч. Тэгээд энэ Зүүн тэр Түжрын цагаан дэрсэн дээр зурхайн хийд байгуулаад тэрэн дээр жаахан зурхай зааж , дэлгэрүүлж байсан юм гэнэ лээ.Их л сайн мэддэг хүн юм гэнэ лээ.

Гантулга: Хаана зурхай сурсан юм бол?

Хайвжунай: Мэдэхгүй.

Гантулга: Тэр найз лам нь гээд, Жасрай гэгээний урд дүрийн лам байсан, Аяа зурхайчийн найз байсан гэдэг?

Хайвжунай: Өө тэр харин Аяа зурхайчийн найз байсан гэдэг чинь тэр Өвөрмонголын.Тэрийг мэдэхгүй.Өвөрмонголын л тэр гэгээний баруун лам байсан юм гэнэ лээ.

Гантулга: Тэр гэгээний дүрийг тэр хошуу ноён тодруулчихсан гэсэн, тэр яасан юм бол?

Хайвжунай: Үгүй ээ, тэр бас тэрэн дээрээ тэгж гэгээн гэж байж байгаад л нас барсан байлгүй дээ.Тэр ноёныг л мүү хэлдэг. Ноён өөрөө хүүгээ Жасрай гэгээнд тодруулчихсан. Тэгээд чи энийгээ аваадах гээд тэр Аяа зурхайчийг тэгж л ирж ,найз нь ирж тэгж л манайд өгсөн юм гэнэ лээ л дээ.Үгүй, өшөө хэлэх юм алга даа.

Гантулга: За баярлалаа.